

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

З Ө В Л Ө М Ж

Нэг. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Зөвлөмж 1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонгон шалгаруулт явуулахаас зайлсхийж, төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байранд иргэнийг гэрээгээр ажиллуулдаг, Засгийн газраас баталсан бүтцийг өөрчилж, шинээр нэгж байгуулдаг, орон тооны хязгаарыг хэтрүүлэн албан тушаалтныг томилдог зөрчлийг арилгах.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.”, 17.2-т “Энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй.”, 17.4-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина.” гэж тус тус заасан байтал Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог, төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоон дээр гэрээ байгуулан ажиллуулдаг эсхүл түр орлон гүйцэтгэгчээр томилдог зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2016 онд 10, 2017 онд 6 иргэнтэй, Архивын ерөнхий газар 1 иргэнтэй, Гадаадын иргэн, харьяатын газар 8 иргэнтэй, Соёл, урлагийн газар 2017 онд 6 иргэнтэй, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2016 онд 4 иргэнтэй, 2017 онд 4 иргэнтэй, Хууль зүй, дотоод хэргийн яам 2016 онд 8 иргэнтэй, Барилга, хот байгуулалтын яам 2016 онд 25 иргэнтэй, Эрчим хүчний яам 2016 онд 10 иргэнтэй тус тус гэрээ байгуулж төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоон дээр томилон ажиллуулсан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь 12 мэргэжилтэн, Биеийн тамир, спортын газар нь 15 мэргэжилтэн, Соёл, урлагийн газар 8 мэргэжилтнийг тухайн албан тушаалд түр томилон ажиллуулж байна. Зам, тээврийн хөгжлийн яам нь 2016 онд 9 (үүрэг гүйцэтгэгчээр), Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2015 онд 13, 2016 онд 9, 2017 оны эхний 5 сарын байдлаар 5 иргэнийг төрийн захиргааны албан тушаалд томилсон байна.

Гэрээт ажилтан нь нэгэнт төрийн жинхэнэ албан хаагч биш учраас Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй бөгөөд төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг

хэрэгжүүлэх явцдаа авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдвол дээрх хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсч, аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо өөртөө болон бусдад давуу байдал олгох эрсдлийг бий болгож болзошгүй байна.

Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага Засгийн газраас баталсан орон тоог хэтрүүлэн томилгоо хийдэг зөрчил гарч байна. Тухайлбал, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын нэгжийн орон тоог батлахдаа Засгийн газрын тогтоолуудыг зөрчиж Бодлого, төлөвлөлтийн газарт Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын алба, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт Авто замын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын алба, Төмөр замын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын албыг тус тус шинээр нэмж байгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт аялал жуулчлал, бусад төсөл хөтөлбөрийн үнэлгээ хариуцсан мэргэжилтний орон тоо батлагдаагүй байхад нэр бүхий иргэнийг томилон ажиллуулжээ.

Сангийн яам нь 17, Татварын ерөнхий газар болон харьяа газрууд нь батлагдсан орон тоог 145 хүнээр хэтрүүлсэн бөгөөд Сангийн яам орон тоогоо хэтрүүлэн авсан 17 иргэнийг төрийн захиргааны албан тушаалын ажлын байранд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байв. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д "...энэ хуулийн 6.4.4/Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/, 6.4.6/Боловсролын зээлийн сан/, 6.4.10/Шинжлэх ухаан, технологийн сан/, 6.5.3/Тариаланг дэмжих сан/-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасан. Гэтэл Байгаль хамгаалах сангийн ажлын албыг татан буулгаагүй байна.

Зөвлөмж 2. Агентлаг нэгээс илүүгүй орлогч даргатай байх, хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь 100-гаас дээш ажилтантай бол дэд дарга (орлогч дарга) 1-тэй, 100-гаас цөөн ажилтантай бол дэд буюу орлогч даргагүй байх чиглэл баримтлах хууль, тогтоолын зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх.

Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол агентлаг нэгээс илүүгүй орлогч даргатай байна", Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр тогтоолын 6.2-т хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь 100-аас дээш ажилтантай бол дэд дарга(орлогч дарга) 1-тэй, 100-гаас цөөн ажилтантай бол дэд буюу орлогч даргагүй байх чиглэл баримтлахыг даалгасан болно.

Гэтэл дээрх хууль, тогтоолын дагуу 1 дэд даргатай байх ёстой Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заагаагүй байхад 2 дэд даргатайгаар, Стандарт, хэмжил зүйн газар нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заагаагүй байхад 2 дэд даргатайгаар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заагаагүй байхад 2 дэд даргатайгаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Нийгмийн халамжийн тухай хуульд заагаагүй байхад 2 дэд даргатайгаар, Иргэний нисэхийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн тухай хуульд заагаагүй байхад 2 дэд даргатайгаар, Гаалийн ерөнхий газар нь Гаалийн тухай хуулийн 267^{1.3}-д Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дарга, дэд даргатай байхаар заасан

байхад 2 дэд даргатайгаар тус тус ажиллаж байна. Мөн Гамшгаас хамгаалах тухай хуульд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд даргад цэргийн дээд цол олгож болохоор зохицуулснаас өөрөөр тэргүүн дэд дарга, дэд дарга нарын талаар заагаагүй байхад 1 тэргүүн дэд дарга, 2 дэд даргатайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Зөвлөмж 3. Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах.

Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын “төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай асуудлыг тодорхой тусгасан байтал, ялангуяа яам, агентлаг, салбарын дарга нарын албан үүргийг түр гүйцэтгүүлэхдээ буюу түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо дээрх журмыг баримтлан түр орлон гүйцэтгэх хугацаа заах, дэд дарга, орлогчтой байгууллагын даргын албан үүргийг нь дэд дарга, орлогчоор, тэд орлох боломжгүй бол чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар, дэд дарга, орлогчгүй байгууллагын даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар гүйцэтгүүлэх” заалтыг зөрчиж байна. *Тухайлбал, Татварын ерөнхий газрын даргын шийдвэрээр 31 хүнийг аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон ба эдгээр 12 нь журмын шаардлага хангаагүй байна.*

Зөвлөмж 4. Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтыг тодорхой албан тушаалд томилогдох гэж буй этгээдэд тохируулан боловсруулж байгаа зөрчлийг таслан зогсоох, дахин ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолт боловсруулах заавар”-ын 1.4 дэх хэсэгт “Ажлын байрны тодорхойлолтыг ажил эрхлэгчид тохируулах бус, тухайн байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай нийцүүлэн ажлын байрны шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулна” гэж заасныг баримтлалгүй тодорхойлолтыг зарим ажлын байр (албан тушаал)-нд томилогдсон этгээдэд тохируулан боловсруулдаг зөрчил арилахгүй байна. *Тухайлбал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтыг 2 хувилбараар боловсруулсан байх ба томилохоор нэр дэвшүүлсэн этгээдэд тохируулан бэлтгэсэн ажлын байрны тодорхойлолтыг хавсарган ХАСУМ-ийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн болно.*

Зөвлөмж 5. Төрийн албанаас чөлөөлөгдснөөс хойш 2 жилийн дотор өөрийн ажиллаж байсан салбарын чиглэлээр хуулийн этгээд байгуулах, өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан, хувь эзэмшсэн, хамтын өмчлөлийн компанитай Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд

хамаардаггүй ажилтан, албан хаагчийг ажиллаж байх хугацаанд нь төртэй тухайн салбар, чиглэлийн гэрээ хэлцэл байгуулах, хамтран ажиллахыг хориглох асуудлыг судалж шийдвэрлэх.

Эрчим хүчний чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 830 компани эзэмшиж байна. Тэдгээрээс 250 компани буюу 30,1 хувь нь нийтийн албан тушаалтан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой 8, Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчидтэй холбоотой 9, төрийн тусгай алба хаагчидтай холбоотой 4, төрийн захиргааны албан тушаалтантай холбоотой 53, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллага, аж нэгжийн албан тушаалтантай холбоотой 143 компани байна.

Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан тушаалтнууд, тэдний гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан, хувь эзэмшсэн, хамтын өмчлөлийн 130 компани эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Энэ нь эрчим хүчний салбарт төрийн өмч, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэх, өөртөө болон бусдад давуу байдал олгох шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Эрчим хүчний чиглэлээр аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйлчилгээ нь авлигын эрсдэлтэй үйлчилгээнд хамаарч байгааг анхаарч, албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй, зөрчил үүсэх, эсхүл зөрчилтэй гэж үзэх ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл мэдэгдэл, тайлбар гаргах үйл ажиллагааг хэвшүүлэх, хяналтыг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж 6. Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гарсан зөрчлийг арилгах, энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтан үндсэн ажлаасаа гадна хэд хэдэн ажил, үүрэг гүйцэтгэж, эрх эдэлж байгааг хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтын хүрээнд хянан үзэж, холбогдох хууль, журамд нийцүүлэн өөрчлөх, үндсэн ажил, чиг үүргийг нь алдагдуулахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, ялангуяа яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарын давхар ажил эрхлэлтэд онцгойлон анхаарах.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалт, давхар ажил эрхлэлтийн журмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгасан. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны албан хаагч нь багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил, ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил үүргийг давхар эрхэлж болох ба давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг биелүүлж ажиллах зохицуулалттай. Нийтийн албан тушаалтан нь төрийн өмчит

болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх, ТУЗ-ийн гишүүнээр ажиллах, хууль болон Засгийн газрын шийдвэрээр нэр бүхий зөвлөл, хороодод ажиллаж байгаа нь зарим тохиолдолд тухайн албан тушаалтны хувьд үндсэн ажил, чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, ачааллыг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй юм. Тухайлбал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нь Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Монголын хөрөнгийн бирж, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Хадгаламжийн даатгалын корпорацийн Үндэсний хорооны гишүүн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тооны бус зөвлөлийн гишүүнээр ажилладаг нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан зорилт чиг үүргээ бүрэн дүүрэн, чанар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэргэжилтэн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай 3 аж ахуйн нэгжид зөвлөх, орчуулагч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн нь төслийн орон тооны бус зөвлөх бөгөөд Бүрэн бус нөхөрлөлийн захирлын үүргийг тус тус давхар гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ 2017 оны байдлаар 15 албан тушаалтан ажлын бус цагаар давхар ажил эрхэлж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 20 албан хаагч ТУЗ-ийн гишүүнээр, 12 албан хаагч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр, “Эрдэнэс Монгол” компанийн болон Хөгжлийн банкны ТУЗ-ийн гишүүнээр тус бүр 1 албан хаагч ажилладаг.

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.8-д “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхээр томилогдсон төрийн захиргааны албан хаагч 2-оос илүү төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллахыг хориглоно” гэж заасан боловч энэхүү заалт практик дээр хэрэгжихгүй байна.

Зөвлөмж 7. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалгүй, шууд томилох эрх зүйн зохицуулалтыг эргэж нягтлах, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-д авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрчлөлт оруулах, ажлын үр дүнг тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын “Хоёр”-ын 2.4-2.10-т зааснаар төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилох, чөлөөлөх, удирдамж чиглэл өгөх эрхийг **Засгийн газар, Сангийн яам, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зэрэг байгууллагууд** хэрэгжүүлж байна. Энэ нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого, чиглэл нэгдсэн зохицуулалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна. Тухайлбал,

-“Эрдэнэс Монгол” ХХК, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг **Засгийн газар**;

-“Эрдэнэс Таван толгой” ХК болон “Эрдэнэс Оюу толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг **Хувьцаа эзэмшигчдийн Хурал /Засгийн газар/;**

-“Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиглэл болгосны дагуу** “Эрдэнэс Оюу толгой” ХК нэр дэвшүүлж, “Оюу толгой” ХХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн хурал**;

-Төрийн банк болон Хөрөнгийн бирж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал”, “Арилжааны төлбөр тооцоо”, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг **Сангийн яам**;

-“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг **Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**;

-бусад төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар** тус тус томилж, чөлөөлдөг болно.

Дээрх журмын “Хоёр”-ын 2.7-д “Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Хөгжлийн банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3-т заасны дагуу Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн хуульд байхгүй зүйл, хэсгийг иш татсан байгааг засч залруулах нь зүйтэй.

ТУЗ-ийн дарга, гишүүн болон төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилохдоо өрсөлдөөнт шалгаруулалтын аргад суурилалгүй шууд томилж байгаа, ялангуяа төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр заан томилох, чөлөөлөхөөр чиглүүлж байгаа нь шударга ёсны зарчимд харш төдийгүй ашиг сонирхлын зөрчил үүсэх, бусдад давуу байдал олгосон шийдвэр гаргахад нөлөөлж болзошгүй юм. Түүнчлэн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийн үйл ажиллагааны үр дүнг тооцдог тогтолцоо бүрдээгүй байна.

Зөвлөмж 8. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө хууль тогтоомжид зааснаас гадуур аливаа төлбөр авахгүй байх, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хандив, тусламж авч хууль тогтоомж зөрчих, иргэдийг чирэгдүүлдэг явдлыг таслан зогсоох.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчид сайдын тушаалаар зөвлөлийн гишүүн, шинжээчийн үүргийг давхар гүйцэтгэж байна. Тус яамны холбогдох албан тушаалтнууд нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүдээр давхар ажиллаж, УИХ-ын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолд заасан 16 орд буюу бусад ордтой холбоотой асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, төсөв хөрөнгийг батлах, нөөцийг тогтоох, хяналт шалгалт явуулах үйл ажиллагаанд шинжээчээр томилогдох буюу ажлын хэсэгт орж ажиллахдаа цалингаас гадуур нэмэлт хөлс авч байна. Сайдын 2016 оны 23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.12-т шинжээч, гишүүдэд хуралдаанд оролцсон тухай бүрт нь олгох ажлын хөлс, Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг зохих журмаар батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлэхээр тусгажээ. Энэхүү журмын дагуу нийтийн албан тушаалтанд зөвлөлийн гишүүнээр ажиллуулсны төлөө ажлын хөлс олгож байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно” гэж заасныг зөрчиж байна. *Тухайлбал, 2015, 2016 онд 8 албан тушаалтныг тус бүр 1-5 ажлын хэсэгт шинжээчээр томилогдон үр дүнгийн урамшуулал, шинжээчийн хөлс*

олгож байгаа нь удирдах албан тушаалтнуудад давуу байдал олгосон гэж үзэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Албан тушаалтан, ... албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг авч болно” гэж, 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэж тус тус заасан болно.

Гэтэл удирдлагаас, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй, өөрийн эрхлэх асуудлын хүрээний, албан үүрэгтэй нь холбоотой, цаашид ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй байгууллага, хувь хүнээс хандив, тусламж шаардсан, авсан зөрчил улсын хэмжээнд түгээмэл байна. Тухайлбал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2015 оны 5 дугаар сард нэр бүхий төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг албан бичгээр хүссэн;

Баянзүрх дүүргийн 50 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төв ОНӨҮГ-аар дамжуулж, 2015 онд нийт 597 иргэн аж, ахуйн нэгжээс 278.070,242 төгрөгийн хандив авсан байх бөгөөд үүний дараагаар хандив авсан аж ахуй нэгжтэй холбоотой шагнах, тендерт шалгаруулах зэрэг шийдвэрийг удаа дараа гаргасан;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа 20 байгууллага нь 2015 онд 406 сая, 2016 онд 493 сая төгрөгийн эд зүйлсийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив, тусламж хэлбэрээр авсан;

Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоол “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.2.1-т “орон сууцны барилга, хотхон хороолол барих хөрөнгө оруулагчдад газар, дэд бүтцийн бусад асуудлыг хөнгөлттэй нөхцлөөр шийдвэрлэн өгч, баригдсан орон сууцны нийт талбайн 2.0 хувийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчийн орон сууцны сан бүрдүүлэх”, мөн нийслэлийн ИТХ-ын 2014 оны 5/14 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.11-т “Нийслэлийн өмчийн харилцааны газар нь орон сууц барихаар газрын зориулалт өөрчлөх зөвшөөрөл олгогдсон газар эзэмшигч, ашиглагчтай орон сууцны барилгын нийт ашигтай талбайн 2 хувьтай тэнцэх хэмжээний орон сууцыг нийслэлийн орон сууцны санд төвлөрүүлэхээр гэрээ байгуулна” гэж заасны дагуу орон сууцны талбайн 2 хувийг үнэ, төлбөргүй авахаар заасан. Улмаар дээрх зохицуулалтын хүрээд Нийслэлийн өмчийн харилцааны газар нь 2015 онд 8 иргэн, аж ахуйн нэгжээс 12 орон сууц, 21 иргэн, аж ахуйн нэгжээс 52909400 төгрөг, 2016 онд 7 иргэн, аж ахуйн нэгжээс 9 орон сууц, 4 иргэн, аж ахуйн нэгжээс 37586568 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Ийнхүү 2 хувийг үнэ төлбөргүй авах тухай гэрээ байгуулах шаардлага тавьж комиссын актанд гарын үсэг зурдаггүй байдал нь гэрээний нэг талын хүсэл сонирхолд нийцээгүй, нийтийг хамарсан албадлагын шинжтэй хууль бус үйл ажиллагаа байна гэж үзэж болохоор байна. Улмаар дээрхи онуудад ашиглалтад

оруулсан орон сууцны тоо, нийслэлийн орон сууцны санд төвлөрүүлсэн орон сууц, мөнгөн хөрөнгийн тооноос эрс зөрүүтэй байгаа нь авлига, ашиг сонирхлын эрсдлийг улам бүр нэмэгдүүлсэн;

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т төрийн болон орон нутгийн өмчит этгээд хандив, тусламж өгөхийг хориглосон байтал Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/163 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 50 жил, Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 60 жилийн ойг тэмдэглэхэд болон 2016 оны А/124 дүгээр тушаалаар Үйлдвэрлэл, урлалын Политехник коллеж, Монгол-Солонгосын Политехник коллежийн 50 жилийн ойн арга хэмжээнд хандив өгч хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн зардлаас гаргахаар тус тус шийдвэрлэсэн зэрэг болно.

Авлигатай тэмцэх газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн цөөнгүй хувийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагад холбогдох хандив, тусламжтай холбоотой асуудал эзэлж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2008 оны 56/64 дүгээр тушаалаар баталсан “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”-д хандив, тусламж авах зөвшөөрлийн талаар нарийвчилсан зохицуулалт үгүйлэгдэж байгааг харуулж байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн “Эрдмийн далай” цогцолбор сургууль нь 2017 онд 55 жилийн ойг тохиолдуулан багш, эцэг эхчүүд, төгсөгчдөөс 20 орчим сая төгрөг хуримтлуулж, сургуулийн няравын арилжааны банкин дахь хувийн харилцах дансанд байршуулжээ.

Түүнчлэн ЕБС-ийн эцэг эхийн зөвлөлөөс сурагчдын дунд аливаа олон нийтийн арга хэмжээ, баяр наадам, үзвэр үйлчилгээ, аялал зугаалга, хандив, тусламжийн арга хэмжээг санаачлан зохион байгуулдаг тул Эцэг, эхийн зөвлөлийг сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг, бодитой хяналт тавьж чаддаг хөндлөнгийн механизм болгох, зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам үлгэрчилсэн загварыг боловсруулж мөрдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Шинэ эхлэл сургуулийн Эцэг, эхчүүдийн зөвлөл гэсэн тамга тэмдэг бүхий албан ёсны төрийн бус байгууллага байгуулан 2016-2017 оны хичээлийн жилд 294 хүүхэд бүрээс 140.000 төгрөгийн хураамж, нийтийн 41.160.000 төгрөгийг хураан авсан байна.

Зөвлөмж 9. Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ашигт малтмалын олборлолт (хаягдал нөөц ашиглах) явуулан түүнээсээ хандив авч, орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлж байгааг таслан зогсоох.

Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө гарган нөхөн сэргээх боломж хомс, хаягдал нөөцийг авалгүй нөхөн сэргээсэн тохиолдолд гар аргаар алт олборлогч иргэд тухайн газрыг дахин ухах асуудал гарч байгаа шалтгаанаар нөхөн сэргээлт хийх нэрээр хаягдал нөөцийг ашиглах замаар асуудал түгээмэл байна. Энэ талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс орон нутгийн удирдах байгууллагаас Монгол Улсын Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 2-т заасан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” гэснийг баримтлан шийдвэр гаргаж, уг ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны А/433 дугаар захирамжаар эвдэрсэн

газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч нарт тавигдах шаардлага, нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах үнэлгээний хуудсыг тус тус баталж, 30 гаруй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. Уг захирамжаар баталсан “нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч нарт тавигдах шаардлага”, аж ахуйн нэгжтэй байгуулсан нөхөн сэргээлтийн гэрээний агуулга нь “нөхөн сэргээлт хийх” гэхээсээ илүү олборлолт хийх, орлого бүрдүүлэхэд чиглэгдсэн байна. Тухайлбал, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавигдах шаардлагад дараахь зүйлийг тусгасан байна:

- Орон нутагт олгох хандив, тусламжийн хэмжээ 1 жилд 100 сая төгрөгөөс багагүй байх;
- Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх;
- Барьцаа хөрөнгийг сонгон шалгаруулалт хийгдэж гэрээ байгуулахаас өмнө тусгай дансанд байршуулна. Дансыг тухайн үед зарлана;
- Хөрөнгө оруулалтын нийт төлбөрийг гэрээ байгуулахаас өмнө Орон нутаг хөгжүүлэх санд байршуулна;
- Угаах төхөөрөмж тутамд 8 сая төгрөгийг усны төлбөрт төлүүлнэ гэх мэт.

Энэ нь нөхөн сэргээлтийн гэрээ нэрээр хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгож, зөвшөөрөлгүй олборлолт явуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь Байгаль орчны яамнаас “газрын хэвлийн мэргэжлийн байгууллагын эрх” авсан байх ёстой. Тус аймагтай нөхөн сэргээлтийн гэрээ байгуулсан 30 аж ахуйн нэгж нь холбогдох зөвшөөрөлтэй эсэхийг шалгах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим хуудсанд нэвтэрч шүүлт хийхэд зөвхөн 10 нь тусгай зөвшөөрөлтэй гэж бүртгэгдсэн байв.

Хоёр. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүнд суртал, чирээдлийг арилгах чиглэлээр:

Зөвлөмж 10. Төрийн байгууллагууд дахь мэдээлэл (бүртгэл, лавлагаа)-ийг нэгтгэсэн “Нэгдсэн цахим сүлжээ бүхий бааз”-ыг бий болгон бэхжүүлэх, Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, салбарын бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь тусгай зөвшөөрөл хүсэгчийн өргөдөлд нийтлэг байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын гэрчилгээ, татварын байгууллагын тодорхойлолт нийгмийн даатгалын шимтгэл төлсөн талаарх лавлагаа зэрэг баримт материалыг хавсаргахыг шаарддаг. Төрөөс үзүүлж буй үйлчилгээ, зарим төрлийн мэдээлэл /лавлагаа/-ийг нэгтгэсэн “нэгдсэн цахим сүлжээ бүхий бааз”-ийг бий болгон ашиглах замаар тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой. Ингэснээр тусгай зөвшөөрөл хүсэгчээс онлайн програмд нэвтэрч өргөдөл гаргах, шаардлагатай тохиолдолд зарим эх материал, файлыг хавсаргах зэргээр онлайн програмд хөтлөгдөн материалаа хүргүүлэх, хэдий хугацаанд шийдвэрлэгдэх, хэн асуудлыг хянаж байгаа зэргийг тухайн этгээд өөрөө хянах боломж бүрдэхийн зэрэгцээ иргэн, хуулийн этгээдээс төрийн өөр бусад байгууллагын хаалга татаж хугацаа алдах, нөгөө талаас албан тушаалтан төрийн байгууллагын цахим мэдээлэлд нэвтрэн холбогдох мэдээллийг авснаар үнэн зөв бодит мэдээлэл авах боломж бүрдэнэ(тусгай зөвшөөрөл олгохтой

холбоотой асуудлаар хязгаарлагдахгүй бусад төрлийн эрх, лиценз олгох, худалдан авах ажиллагаанд оролцох зэрэгт ач холбогдолтой).

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар Банк, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 10, Санхүү, эдийн засгийн чиглэлээр 8, Хууль зүйн чиглэлээр 9, Байгаль орчны чиглэлээр 6, Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр 10, Түлш, эрчим хүчний чиглэлээр 3, Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 1, Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр 15, Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 6, Эрүүл мэндийн чиглэлээр 8, Зохиогчийн эрх, патентын чиглэлээр 1, Барилга, хот байгуулалтын чиглэлээр 4, Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр 8, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр 4, Стандарт, хэмжил зүйн чиглэлээр 1, Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр 8, Батлах хамгаалах чиглэлээр 1, Гамшгаас хамгаалах чиглэлээр 1, нийт 20 чиглэлийн үйл ажиллагаанд 110 гаруй төрлийн тусгай зөвшөөрөл (энд аливаа төрлийн эрх, лиценз олгох, бүртгэл хөтлөх зэрэг асуудлыг оруулаагүй болно) олгодог ба Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.2-ын 1-д заасан “Зөвшөөрөл лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах” гэсэн ажлыг эхлүүлэх шаардлагатай байна. Шинээр боловсруулах Зөвшөөрлийн тухай хуулийг боловсруулахдаа хэд хэдэн асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрт үйлчлэх мэргэжлийн холбоодыг байгуулан ажиллуулах асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийг судлах, ТББ-ын статустай хуулийн этгээдийг байгуулан ажиллуулах талаар хуульд тусгайлсан зохицуулахгүй байх, ялангуяа нэр заан тусгахгүй байх, энэ нь давуу байдал олгоход чиглэсэн зохицуулалт байж болзошгүйг анхаарах, зайлшгүй байгуулан ажиллуулах шаардлагатай бол тухайн тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг тэдэнд шилжүүлэх (Татварын мэргэшсэн зөвлөхийн тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиудад татварын мэргэшсэн зөвлөх болон хөрөнгийн үнэлгээчдийг эгнээндээ нэгтгэсэн тэдгээрийн эрх ашгийг хамгаалах зорилготой Төрийн бус байгууллага ажиллахаар зохицуулсан. Энэ нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн “иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах” зорилтыг хангахаас илүү төрийн бус байгууллагын орлогын эх үүсвэрийг бүдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болгоход хүргэсэн зохицуулалт болсон байж болзошгүй);

Зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой, салбарын хуулиар нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах;

Хууль хоорондын уялдааг судлан зохицуулах (Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд “хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаа”-аар, Гаалийн тухай хуульд “гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 3 хүртэл жилээр олгохоор хуульчилсан ба гаалийн байгууллага уг зөвшөөрлийг олгохдоо 1 жил гэж олгодог практик үйлчилж байна);

Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох эрхийг тодорхой субъектэд олгоогүй тохиолдолд албан тушаалтанд сонголт хийн тогтоох боломжийг олгохгүй байхад анхаарах(Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоход 1800000-4500000 төгрөгийн хураамж төлөх ба энэ хязгаарт тохируулан гаалийн байгууллагын удирдлага ялгавартай хураамж авч болох боломжтой зохицуулагдсан, мөн хугацааг анх олгосон хугацаагаар сунгах хуулийн зохицуулалттай тул 1 жилээр сунгахад мөн л

1800000-4500000 төгрөгийн хураамжийг төлөхөөр байгаа нь улсын төсөвт хөрөнгө төвлөрөх сайн талтай ч иргэн, хуулийн этгээдийг дэмжих талаасаа шударга бус);

Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор хуульчилсан тохиолдолд түүнтэй холбоотой харилцааг зохицуулсан журмыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд батлах эрх олгохгүй байх(Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 138.1.6-д заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллагаас баталсан журмын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.” гэж заасан байхад хууль 10 жил хэрэгжиж байхад Гаалийн ерөнхий газрын дарга нь “Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг батлаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр нэр бүхий 4 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон) гэх мэт.

Зөвлөмж 11. Тусгай зөвшөөрөл хүсэгчээс хуульд заагаагүй баримт, материал шаардаж, төлбөр тогтоон чирэгдэл учруулж буй явдлыг таслан зогсоох, зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар уг асуудлыг шийдвэрлэх.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т тусгай зөвшөөрөл хүсэгчээс “энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардах”-ыг хориглосон. Гэтэл бодит байдалд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хуульд заагаагүй бичиг баримт, төлбөр хураамжийг шаардаж чирэгдэл учруулсаар байна. Тухайлбал, Сангийн яам “аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг олгохдоо 6 (мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, аудиторын туслахаар 3 жил ажилласан байх, эсхүл Татварын цэнхэр дэвтэр, үндсэн ажлаас гадуурх дэвтэр, эхлэлийн баланс, техник тоног төхөөрөмжийн жагсаалт, түрээсийн гэрээ), “*Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл*”-ийг олгохдоо 19 (Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/24 дүгээр тушаалаар “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, хугацаа нь дуусгавар болсон тусгай зөвшөөрлийг сунгах, цуцлах, түдгэлзүүлэх эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж, уг асуудлыг судлан санал боловсруулах удирдамжийг батлан мөрдүүлсэн) төрлийн баримт, материал шаарддаг, мөн “Эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг олгохдоо тусгай зөвшөөрөл хүсэгчээс хуульд заагаагүй 13 төрлийн шалгуур тавьсан;

Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын ажиллах журам”-ыг баталж, комиссыг ажиллах нөхцлөөр хангаж, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор үйлчилгээний хөлс тооцох журмыг боловсруулан мөрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулан ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төвд даалгасан. Үүний дагуу Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2012 оны Б/36 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”-ыг батлан тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнийг 100000, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнийг 200000-2400000 төгрөг байхаар тус тус тогтоосон. Тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнэ болох 100000 төгрөгийг яамны, улсын тэмдэгтийн хураамжийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнийг Эрчим хүчний хөгжлийн төвийн дансанд тус тус төвлөрүүлсэн;

Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6.2-т заасан “Энэ хуулийн ... 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.4 дэх хэсэг, ... заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.” гэснийг зөрчин “Тэмдэгтийн хураамжийн төлбөрийн хэмжээ, зардлын жишиг”-ийг тогтоосон. Өөрөөр хэлбэл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолд заасан хэмжээг өөрчлөн тогтоосон. Тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн худалдаа эрхлэх зөвшөөрлийг олгоход хураах хураамжийн хэмжээг хуулиар 50000 төгрөг гэсэн байхад 110000 төгрөг болгон нэмэгдүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн түүхий эдийн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг олгоход хураах хураамжийн хэмжээг хуулиар 500000, сунгахад 200000 төгрөг гэсэн байхад олгоход 110000, сунгахад 110000 төгрөг гэж бууруулан тогтоосон;

Баянхонгор аймгийн Засаг дарга нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан “Энэ хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” гэснийг зөрчиж тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон ба ийнхүү тогтоохдоо спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хураамжийн хэмжээг хуульд заасан хязгаараас 100000-200000 төгрөгөөр хэтрүүлэн тогтоосон байна.

Зөвлөмж 12. Байгаль орчны сайдын 2001 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 218 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-ыг дахин хянан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэх, төр захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах.

Байгаль орчны сайдын 2001 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 218 дугаар тушаалаар “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-ыг баталсан. Уг түр журмыг 17 жил мөрдөж байна. Энэхүү журамд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд дархан цаазат газарт явуулж болохгүй үйл ажиллагааг дурдсаны зэрэгцээ 12 дугаар зүйлийн 5-д “энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих”, 9-д “өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх”-ийг хориглохоор тусгасан болно. Дээрх хуулиар тогтоосон хамгаалалтын дэглэмийн зохицуулалтыг үл харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нар тусгай хамгаалалттай газар нутагт 1706 иргэн, аж ахуйн нэгжид газар ашиглах гэрчилгээ олгожээ. Өөрөөр хэлбэл, дархан цаазат газарт иргэн, аж ахуйн нэгж барилга байгууламж барин шугам сүлжээ татаж, суурьшлийн бүс бий болгосон. Хан-Уул дүүргийн хэмжээнд Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа 359 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас 194 нь газар ашиглалтын төлбөрөө огт төлөөгүй байгаа нь Газрын төлбөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Зөвлөмж 13. Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл байгааг анхааралдаа авч, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагчийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгох, хяналт, хариуцлагыг чангатгах, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлэх.

Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно” гэж заасан байхад Баян-Өлгий аймгийн Засаг дарга 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар захирамжаар “Ийгл-Алтай” ХХК, “Алтай Пикс” ХХК-д ховор амьтан агнах эрх олгож гэрээ байгуулсан. Уг гэрээг байгуулахдаа Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1/амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбогдуулан гаргасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах/ дэх заалтыг буюу хуулийн хамаарахгүй зүйл, заалтыг үндэслэсэн байна.

Мөн Баян-Өлгий аймгийн Монгол Алтайн нурууны тусгай хамгаалалттай газрын захиргааны дарга “Монгол сафари” ХХК-ийг хариуцан ажилладаг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутгийг өөрийн үүсгэн байгуулсан “Орман ан” ХХК-ны нэр дээр шилжүүлснийг Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон байна.

Түүнчлэн Монгол Улсад Алтайн угалз агнуулахад төлүүлж байгаа төлбөрийн хэмжээ/24 сая төгрөг/-г гадаад зах зээл дээрх үнэ/гадаад зах зээлийн үнэ 100000 ам.доллар/-тэй харьцуулбал нэлээд зөрүүтэй тогтоон мөрдөж байна.

Зөвлөмж 14. Захиргааны байгууллага хуульд эрх олгоогүй байхад хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлж, үйл ажиллагааг журамлах, төлбөр, хураамж тогтоох зэрэг нийтлэг зөрчлийг арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх.

Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй актыг улсын хэмжээнд мөрдөж байгаа зөрчил түгээмэл байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал/ИТХ/ нь хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж мөрдүүлэхээр заасан болно. Гэтэл ИТХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлыг Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор шийдвэрлэх зөрчил нийтлэг гарч байна. Тухайлбал, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 205 дугаартай тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг баталж мөрдүүлсэн бөгөөд захиргааны эрх зүйн хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2017 оны 52 дугаар тогтоолоор “Хадлан бэлтгэх, ашиглах үйл ажиллагаанд мөрдөх, хяналт тавих журам” баталж аймгийн хэмжээнд мөрдүүлсэн байх бөгөөд уг журмыг бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулахад хуульд заасан шаардлага хангаагүй учир зөрчил арилгуулах дүгнэлт гаргаж буцаасан боловч хүчин төгөлдөр хэмээн мөрдүүлж аймгийн нутаг дэвсгэрээс байгалийн хадлан бэлтгэсэн аж, ахуйн нэгж, иргэдээс энэ журмыг үндэслэн төлбөр, хураамж авчээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, тодотгол хийх, өөрчлөлт оруулдаг байдал орон нутагт нийтлэг гарч байна. Тухайлбал, Дархан Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

2016 оны 10, 46 дугаар тогтоол, Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 44 дүгээр тогтоолоор Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 15 дугаар тогтоолоор Ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарь, тавих журмыг тус тус баталсан нь ИТХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргаж холбогдох хуулийг зөрчжээ.

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.19-д Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тогтоох эрхийг Сангийн сайдад олгосон байхад Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 47 дугаар тогтоолоор “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ыг баталж, Сангийн сайдын 2012 оны 239 дугаартай тушаалаар баталсан журмыг дэлгэрүүлэн дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоод зочид төлөөлөгчдийг хүлээн авах, гадаад улсад айлчлал хийх, дүүргийн нэрэмжит тэмцээн уралдаан, наадам, тэмдэглэлт ойн арга хэмжээ зохион байгуулах, дүүргийг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааны зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхээр нэмж тусгаж зарцуулсан байна.

Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар тогтоолоор Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмыг баталсан. Энэхүү журмыг нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөж байгаа бөгөөд хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байна. Түүнчлэн уг журмыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны А/40, 2016 оны А/37, Багануур дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 20 дугаар тогтоолоор дүүргийн хэмжээнд дэлгэрүүлэн журамлаж, шат дамжлага, төлбөр хураамж бий болгосон нь холбогдох хууль тогтоомжийг мөн зөрчиж байна.

Зөвлөмж 15. Салбарын үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай дүрэм, журам, эрх зүйн актыг нэр даруй батлан гаргах, эрх зүйн орчныг сайжруулах.

Мал эмнэлэг, үржлийн газрын даргын малын үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2015 оны А/17 дугаар тушаалаар 170.597.050 төгрөг, А/25 дугаар тушаалаар 63,410.600 төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Цөм сүргийн малд үзлэг ангилалт хийх, санхүүжилтийг шилжүүлэх тухай” 2015 оны А/93 дугаар тушаалаар 157.924.900 төгрөгийг, 2015 онд нийт 391.932.550 төгрөг улсын төсвөөс гаргажээ. Үзлэг, ангилалт хийх тарифыг аймаг тус бүр ИТХ-ын шийдвэрээр харилцан адилгүй тогтоож, гаргасан байна.

Зөвлөмж 16. Хууль тогтоомж зөрчиж, иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээний үнэ, хөлс тогтоосон журмыг хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл хүсэгчээс хуульд зааснаас бусад төлбөр, хураамж авч буй явдлыг таслан зогсоох, улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй аж ахуйн нэгжүүдээс төлбөрийг нөхөж гаргуулан авах, хураамжийг тухай бүр хураан авч, төсөвт бүрэн төвлөрүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход авах хураамжийн хэмжээг хатуу тогтоосон болно.

Гэтэл Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын ажиллах журмыг баталж, комиссын ажиллах нөхцөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор үйлчилгээний хөлс, тооцох журмыг боловсруулан мөрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулан ажиллахыг Эрчим хүчний хөгжлийн төвд даалгасны дагуу тус төвийн захирлын 2012 оны Б/36 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”-ыг батлан тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнэ, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнийг тус тус батлан мөрдүүлсэн нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг зөрчиж байна.

Засгийн газрын 2015 оны 73 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Байгалийн ховор ургамал, дэрэвгэр жиргэрүүг Байгалийн ургамлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад тогтоомжид заасны дагуу экспортод гаргах” зөвшөөрөл олгохыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдад даалгасан байхад 2015 оны 1 дүгээр сарын 01-ээс 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд Монгол Улсын хилээр 88,500 кг дэрэвгэр жиргэрүү ургамлыг гадаадад гаргасны тэмдэгтийн хураамж 176.1 сая төгрөг, Байгалийн нөөц ашигласны төлбөр 235.2 сая төгрөг, нийт 411.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Экспортолсон дэрэвгэр жиргэрүүг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг нь холбогдох мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн дүгнэлтээр тогтоогдсон тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.17-д заасны дагуу эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгон хураамж авч 697.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжтой байжээ.

Ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 3000 төгрөг төлөхөөр Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.13-т заасан болно. Гэтэл 2015 онд 11 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 117 тонн, 2016 онд 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 1600 тонн, 2017 оны эхний 3 сарын байдлаар 4 иргэн, аж ахуйн нэгж 610 тонн самрын идээг гадаадад гаргахдаа кг тутамд төлөх 3000 төгрөгийг, нийт 2327 тоннд оногдох 6,9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21.1.2-21.1.30-д байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон бөгөөд дээрх заалтын дагуу сүүлийн 3 жилийн байдлаар улсад төлөх ёстой хуш модны самрын идээний хураамжаа төлөөгүй хуулийн этгээдээс өндөр үнийн дүн бүхий хураамж төлөх ёстой байсан аж ахуйн нэгжийг түүвэрлэн үзэхэд 11 байгууллага байна. Тухайлбал, 2015 он “Жи Си-Эс” ХХК 24 сая төгрөг, 2016 онд “Эс Си Интернэшнл” ХХК -960 сая төгрөг, “Оюу цагаан барс” ХХК 1 тэрбум 800 сая төгрөг, “Эко самар” ХХК 600 сая төгрөг, “Буман боргоцой” ХХК 288 сая төгрөг, “Эс Си Интернэшнл” ХХК 1 тэрбум 500 сая төгрөг, 2017 онд “Эс Си Интернэшнл” ХХК 1 тэрбум 500 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг тус тус төлөөгүй байна.

Эрүүл мэндийн салбарт иргэдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үндэслэлгүй төлбөр хураамж авах, хуулиар эрх олгогдоогүй этгээд үнэ тариф тогтоон мөрдүүлсэн, Засгийг газрын гишүүд хамтран батлах ёстой журмыг бие даан батлан хэрэгжүүлж хууль зөрчиж байна. Тухайлбал, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран, Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн

бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журмыг рүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар холбогдох хуулиудад заасан байхад Эрүүл мэндийн сайд дангаар баталсан байна.

Энэхүү тушаалаар тус яам 2015 оноос одоог хүртэл эмнэлгийн тусламж, үйлчилгээнд бусад хууль, тогтоомжид заагаагүй төлбөр, хураамжийг тогтоон мөрдүүлж байна. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг батлахдаа магадлан итгэмжлэх Зөвлөлийн хурлын зардал болон Зөвлөлийн гишүүдийн хөлсийг тогтоожээ. Түүнчлэн Зөвлөлийн гишүүдийн 60 хувь нь төрийн захиргааны албан хаагч бөгөөд тэдгээрт үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө давхар хөлс олгох нөхцөлийг бүрдүүлжээ.

Зөвлөмж 17. Үйлчилгээний чанар, хүртээмжид судалгаа хийж, цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, цахим гарын үсэг олгох, хаягжуулах, баталгаажуулах ажлыг түргэтгэх.

Засгийн газраас төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр хэд хэдэн шийдвэр гаргасан. Засгийн газрын 2005 оны 216 дүгээр тогтоолоор “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг баталж, төрийн үйлчилгээний 70-аас доошгүй хувийг онлайн хэлбэрт оруулахаар, Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг баталж цахим хэлбэрт шилжих боломжтой төрийн үйлчилгээ 2016 онд цахим хэлбэрт шилжсэн байхаар, 2015 оны “Төрийн үйлчилгээний цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 254 дүгээр тогтоолоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой 32 байгууллагаас үзүүлдэг нийт 167 төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахаар тус тус шийдвэрлэсэн боловч нөхцөл байдалтай газар дээр нь танилцахад тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй, төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй, төрийн үйлчилгээний хүнд суртал, олон шат дамжлага, чирэгдлийг арилгах, бууруулахад дорвитой нөлөө үзүүлээгүй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр үе шат буюу 2016-2019 онд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар тусгасан тул бүх шатны төрийн байгууллагыг цахим хэлбэрээр өргөдөл, гомдол хүлээн авах боломжийг бүрдүүлэх, газар олголт, цэцэрлэг, сургуулийн бүртгэл, эмнэлэг, сувилалд үйлчлүүлэх дараалал, нийгмийн халамжийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголт, жолооны үнэмлэх болон бүх төрлийн лавлагаа, тодорхойлолт олгох зэрэг төрийн боломжит бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн албан тушаалтны нөлөө, бусад хүчин зүйлээс ангид, авлигын эрсдэлгүй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг үзүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолын хавсралтад Хил хамгаалах ерөнхий газар 3, Гадаадын иргэн, харьяатын газар 14, Улсын бүртгэлийн ерөнхий газар /хуучин нэрээр/ 12, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2, Архивын ерөнхий газар 11, Цагдаагийн ерөнхий газар 8 үйлчилгээг тус тус цахим хэлбэрт шилжүүлэхээр тусгагдсан боловч Архивын ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар лавлагааны үйлчилгээг тус тус цахим хэлбэрт шилжүүлж, бусад үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээгүй буюу Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо цахим хэлбэрт шилжиж иргэний улсын бүртгэлийн 1958-1988 оны архивын баримт бичиг 100 хувь, иргэний гэр бүлийн

байдал, хувийн хэргийн бүртгэл 97,9 хувь, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив нь нийт 8 аймагт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2015 оноос өмнөх архивын баримт бичиг цахим хэлбэрт шилжсэн байхад үйлчилгээ үзүүлэхдээ шаарддаг баримт бичгийг цөөрүүлэх, лавлагааг цахим хэлбэрээр олгох нөхцөл боломжийг бүрдүүлээгүй байна.

Архивын лавлагааны үйлчилгээг бүхэлд нь цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой боловч цахим гарын үсэг олголт болон иргэн, хуулийн этгээдийн хаягжуулалт, түүний баталгаажилт удааширсантай холбоотойгоор хойшлогдсон байна.

Зөвлөмж 18. Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв хоорондын уялдаа холбоог сайжруулах, төвийн цахим системд Засгийн газрын байгууллагуудыг холбох, төвөөс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх арга хэмжээ авах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Засаг даргын харьяа байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлэх, зарим үйлчилгээний шийдвэрлэх хугацаа, иргэдэд учруулж буй хүндрэл, чирэгдлийг багасгах зорилгоор “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг Мишээл экспо, Дүнжингарав, Драгон төвүүдэд байгуулсан нь зохион байгуулалтын зөв шийдэл болжээ. Гэвч нийслэлийн байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээ, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг харьяа байгууллагууд хэрхэн шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн чанар, байдалд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд нь хяналт тавих эрх зүйн зохицуулалт байхгүй /уг төв гомдол мэдээлэл хүлээн аваад холбогдох байгууллагад шилжүүлдэг гэтэл иргэд өргөдөл, гомдол гаргасан газраасаа шийдвэрлэлтийн үндэслэл, чанарыг шаарддаг/. Өргөдөл, гомдлыг нийслэлийн харьяа байгууллага руу шилжүүлэх үйл явц цахим хэлбэрт шилжсэн ч Засгийн газрын харьяа байгууллагуудад уг системийг бүрэн нэвтрүүлээгүйгээс үүдэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт удааширч, зардал ч багагүй гарч байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр авлигын эрсдэл буурах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдах, шат дамжлага, хүнд суртал, чирэгдэл арилах, үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим хэлбэрээр төлөх, албан хаагчдын ажлын бүтээмж сайжрах зэрэг олон давуу талтай.

Гурав. Төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг сайжруулах чиглэлээр

Зөвлөмж 19. Төсвийн орлогын бүрдүүлэлт, төсөвт төвлөрүүлэх орлогыг нөхөн төлүүлэх, төсвийн орлогыг зөвхөн хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн банк, дансанд төвлөрүүлэх, мөрдөгдөж буй эрх зүйн акт/журам/-ыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн батлах, төсвийн орлого бүрдүүлэлт болон Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, тавих хяналт, хариуцлагыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлэх.

Монгол Улсын хилээр 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 30-ны хооронд гадаадад гаргасан 88500 кг байгалийн ховор ургамал/дэрэвгэр жиргэрүү/-ын тэмдэгтийн хураамж 176.1 сая төгрөг, байгалийн нөөц ашигласны төлбөр 235.2 сая төгрөг, нийт 411.3 сая төгрөгийг, 2015-2017 онд зарим аж ахуйн нэгж/”Жи Си-Эс” ХХК 2015 онд 24 сая төгрөг, 2016 онд “Эс Си

Интернэшнл” ХХК 960 сая төгрөг, “Оюу цагаан барс” ХХК 1,8 тэрбум төгрөг, “Эко самар” ХХК 600 сая төгрөг, “Буман боргоцой” ХХК 288 сая төгрөг, Эс Си Интернэшнл ХХК 1,5 тэрбум төгрөг, 2017 онд “Эс Си Интернэшнл” ХХК 1,5 тэрбум төгрөг/ хуш модны самрын идээ түүж бэлтгэсний тэмдэгтийн хураамж нийт 6,9 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлээгүй, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа 194 иргэн, аж ахуйн нэгж газар ашиглалтын төлбөрөө төлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэж заасан байхад Гадаадын иргэн, харьяатын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлээр төвлөрүүлсэн тэмдэгтийн хураамж, торгуулиас олсон орлогыг Сангийн сайдын баталсан, Сангийн яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Голомт банкны хооронд байгуулсан 2014 оны 132/15-10/2014/68/65 дугаартай гэрээний дагуу Голомт банкин дахь дансанд төвлөрүүлж, тухайн өдөртөө Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн Улаанбаатар хотын банкин дахь данс руу шилжүүлж байна.

Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааг бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явуулж буй гадаад, дотоодын компаниудаас төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнд төвлөрүүлдэг хөрөнгийг зарцуулах журам”-ыг мөрдсөөр байна. Гэтэл дээрх журмыг батлахдаа үндэслэл болгосон 1991 оны Газрын тосны тухай хууль, Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам” нь 2014 оны 07 дугаар сарын 01-нээс Газрын тосны тухай хууль(шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр хүчингүй болсон. Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих санд 2015 онд 1,3 тэрбум төгрөг, 2016 онд 2.1 тэрбум төгрөгийг Сангийн яаманд бүртгэлгүй дансанд тус тус төвлөрүүлж, захиран зарцуулсан бөгөөд 2017 онд 7 сая доллар төвлөрөхөөр байна.

Хилийн чанад(Бээжин, Москва, Сөүл, Берлин, Улаан-Үүд дэх дипломат төлөөлөгчийн газраас бусад)-д байгаа дипломат төлөөлөгчийн газруудад визны хураамж, нотариатын үйлчилгээний орлогыг төрийн санд төвлөрүүлээгүй байна. Тухайлбал, Бразил Улс дахь элчин сайдын яам нь 2015 оны төсвийн үлдэгдэл 20,776.03 ам.доллар, 2015 оны санхүүжилтийн үлдэгдэл 1,822.43 ам.долларыг тус тус төвлөрүүлээгүй.

Зөвлөмж 20. Боловсролын зээлийн сан /Сургалтын төрийн сан/-тай байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй, сургуулиа төгсөөгүй, Монгол улсад ирж ажиллаагүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, нээлттэй мэдээлэх, хяналт шинжилгээ хийх, холбогдох этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх, боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцагчдыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, шинжээчдийн багийн төлөөлөлтэйгээр сонгон шалгаруулж, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох.

Боловсролын зээлийн сангийн зээлээр 1997-2011 онд гадаад улсад суралцан сургуулиа төгсөөд бүртгүүлээгүй нийт 344 иргэн байгаа бөгөөд тэдгээрт олгосон сургалтын төлбөр 8.367.786 ам.доллартай тэнцэж байна. Тус сангийн зээлээр сургалтад хамрагдсан суралцагчид үл хөдлөх хөрөнгө барьцаалах гэрээг давхар байгуулдаг.

Дээрх 344 иргэдээс судалгаанаас түүврийн аргаар сонгон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангаас судлан үзэхэд 15 иргэний нэр дээрх үл хөдлөх хөрөнгөнд сургалтын төрийн сангийн барьцаа бүртгэлтэй, 80 иргэний Сургалтын төрийн сантай байгуулсан барьцааны гэрээг бүртгэсэн бүртгэл байхгүй, 9 иргэний барьцаа хөрөнгийг сургалтын гэрээний үүргээ биелүүлсэн үндэслэлээр барьцаанаас чөлөөлсөн байна.

Зөвлөмж 22. Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг үндэслэлтэй, оновчтой болгон тогтоож, бүртгэл-хяналтын тогтолцоог бүрдүүлэх, цэцэрлэгийн хүүхдийн бүртгэлийн цахим системийг нэвтрүүлэх, хувьсах зардлын талаар дотоодын хяналт-шинжилгээ үнэлгээний чанар, үр дүнг дээшлүүлэх, хууль бусаар олгогдсон хувьсах зардлыг төсөвт буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авах.

Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол/Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай/-ын 1 дэх хэсгийн 6-д төсвийн зардал хэмнэх чиглэлээр “төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс олгох хувьсах зардлын хэмжээг сургалтын төлбөртэй нь уялдуулан ялгавартай тогтоож байхаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах” гэснийг хэрэгжүүлээгүй, иргэд, салбарын төрийн бус байгууллагуудтай хийсэн уулзалт, фокус ярилцлагаар хувийн өмчийн өндөр төлбөртэй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд нь төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн нэг адил хувьсах зардлын санхүүжилтийг төрөөс авч байгаад шүүмжлэлтэй хандаж байсан. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд сурагч бүрийг регистрийн дугаараар бүртгэлд оруулсан цахим систем 2014 оноос хэрэгжиж 13.000 хүүхдийн давхардлыг арилгаснаар хувьсах зардлыг давхардуулан авдаг зөрчил үгүй болсон байна. Гэвч 2017 оны 1 дүгээр улиралд хийсэн хяналт шалгалтын явцад цэцэрлэгийн хүүхдийн цахим бүртгэл бүрэн хийгдээгүй байгаа нь хувьсах зардлыг давхардуулан олгох эрсдэлийг бий болгож байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас тусгай зөвшөөрөл аваагүй ШУТИС-ийн харьяа Коосэн ахлах сургууль 2015 оноос 1 хүүхдийн 3,0 сая төгрөгийн төлбөртэй сургах үйл ажиллагаа явуулсан ба хувьсах зардалд 2015 онд 7.604.680 төг, 2016 онд 43.910.209 төг, 2017 онд 21.004.100 төг, нийт 72.518.989 төгрөгийн санхүүжилт авсан зөрчил байна.

Зөвлөмж 23. Сурах бичгийн ашиглалтын судалгааг гаргах, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас сурах бичгийн талаар баримтлах бодлогын хүрээнд зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх.

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.7-д “Цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн байгууллагыг зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгээр хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах”-аар заасан.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2008 оны 12 дугаар сарын 11-ний байгуулсан “Боловсролын салбарын шинэчлэл төсөл”-ийн буцалтгүй тусламжийн гэрээний дагуу ЕБС-уудын “Номын түрээс”-

ийн үйл ажиллагаанаас “Сурах бичгийн түрээсийн тогтолцоо-Эргэлтийн сан”-д 3,2 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Гэтэл сурах бичгийг түрээсэлснээс олсон орлогын төвлөрүүлэлтэд тавих хяналт сул, хариуцах байгууллага, албан тушаалтан тодорхойгүй, түрээсийн төлбөрийн орлого “царцсан” байдалтай Төрийн сангийн дансанд төвлөрч байна.

Зөвлөмж 24. Аудитын байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар төсөв, санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан зөрчил /түгээмэл/ их, аудитын байгууллагаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ хангалтгүй байгаа нь авлигын гэмт хэрэг гарах эрсдэл үүсгэж байгаа тул төсөв, санхүүгийн хариуцлага, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”-ыг тусгасан ба Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2/төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр/-ын 5-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Гэтэл төсвийн хөрөнгийг баяр, наадам, ой тэмдэглэх, ажлын үр дүнг харгалзахгүйгээр бүх ажилтанд урамшуулал олгох зэргээр хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчил нэлээд байна. Тухайлбал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/223 дугаар тушаалаар Тулгар төрийн 2225 жил, Их Монгол Улсын 810 жил, Ардын хувьсгалын 95 жилийн баяр наадам тэмдэглэхтэй холбогдуулан хүлээн авалтын үйл ажиллагаанд 3,3 сая төгрөг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны А/99 дугаар тушаалаар Засгийн газрын гишүүдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаанд 1,54 сая төгрөг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/163 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 50 жил, Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 60 жилийн ойг тэмдэглэхэд сургууль тус бүрт 500000 төгрөг, 2016 оны А/124 дүгээр тушаалаар Үйлдвэрлэл урлалын Политехник коллеж, Монгол-Солонгосын Политехник коллежийн 50 жилийн ойн арга хэмжээнд тус бүр 1 сая төгрөгийг хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн зардлаас тус тус зарцуулсан.

Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 253 дугаар тушаалаар Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан яамны нийт албан хаагчдад 10,2 сая төгрөгийн урамшуулал, Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг олгохдоо ажилласан хугацаа, ажлын үр дүнг харгалзахгүйгээр бүх ажилтанд олгосны дотор шинээр ажилд орсон 23 албан хаагчид ажлын үр дүнг дүгнэхгүйгээр нийт 5,4 сая төгрөг олгосон, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2015 онд нийт албан хаагчдад 222,3 сая төгрөгийн, 2016 онд 286,5 сая төгрөг, сүүлийн 2 жилийн хугацаанд үр дүнгийн гэрээний урамшуулалд нийт 508,8 сая төгрөг олгожээ.

Дээрх урамшууллыг олгохдоо төрийн албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж өндөр амжилт гаргасан болон онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэнийг харгалзахгүйгээр нийт албан хаагчдад хавтгайруулан олгосон зэрэг нь Төрийн албаны тухай хуулийн 19.2-т

“Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн ...шагнаж урамшуулах, ...асуудлыг шийдвэрлэнэ.”, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох журам”-ын 5-д “.... мэргэжлийн өндөр үр чадвар, идэвх санаачилга, албаны болон албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа албан хаагчид ... мөнгөн шагнал олгож болно” гэж заасныг, мөн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 113, 114, 115, 116, 117 дугаар тушаалаар 5 албан хаагч/жолооч/-д ажлын хөлсийг олгохдоо ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээгээр үр чадварын нэмэгдлийг 25 хувиар олгохоор шийдвэрлэсэн нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “....төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий ажил үүргийг Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэх ..” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Буцалтгүй тусламж, тэтгэмж, тэтгэлэг, зээл олгохдоо бодит нөхцөл байдалд үндэслээгүй, мөрдөгдөж буй журам, үзүүлэлтийг баримтлаагүй байна. Тухайлбал, Иргэний нисэхийн ерөнхий газар нь өөрийн зардлаар гадаад улсад нарийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг бөгөөд 2016 оны 10 дугаар сарын 1-ны өдрийн байдлаар 30 төрлийн мэргэжлээр 13 улсад 107 оюутан суралцаж 25 оюутан төгссөн байна. Үүнээс мэргэжлийн сургалтанд 25, бакалаврын сургалтанд 56, магистрантурт 20, докторантурт 6 оюутан суралцжээ. Эдгээр оюутны төлбөрт 2013 онд 2.7 тэрбум төгрөг, 2014 онд 2.7 тэрбум төгрөг, 2015 онд 3.4 тэрбум төгрөг, 2016 онд 838 сая төгрөг буюу 4 жилийн хугацаанд нийт 9.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Б/35 дугаар тушаалаар тус дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын гэр бүлийг дэмжих, амьдралын баталгааг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж 20 сая төгрөгийг олгосон ба тус хэлтсийн дарга нь 5 хоногийн дараа буюу 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/40 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн байна. Тушаалын үндэслэлд Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох талаар дурдсан боловч уг хөтөлбөр 2016 онд хэрэгжиж дууссан, тэтгэмж олгох асуудлаар удирдах зөвлөлийн хурал хийгээгүй, шийдвэр гаргаагүй байна. Түүнчлэн тус хэлтсийн даргаар ажиллаж өмнө нь ажиллаж байсан албан тушаалтанд 2016 онд 4,9 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгожээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчин, уур амьсгалын санд зориулан байгуулсан Ажлын албыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-д заасныг хууль зөрчин өнөөдрийг хүртэл ажиллуулж байгаа бөгөөд Ажлын албаны урсгал зардалд тус сангаас санхүүжилт хийгдсээр байна. Тус санд 2015 онд 2.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 2,1 тэрбум төгрөгийн зарцуулалт, 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар тус санд 448,1 сая төгрөгийн орлого төвлөрч, 283,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зөвлөмж 25. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох журам, аргачлал, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах.

Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 138 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх

хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам"-ыг баталсан бөгөөд энэ журмын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд иргэд, аж ахуйн нэгжээс 2016 онд нийт 700 гаруй төсөл ирүүлснээс 212 аж ахуйн нэгж, иргэнд зээл олгох шийдвэр гаргасан байна. Хэрхэн сонгон шалгуулсан нь тодорхойгүй, холбогдох төсөл болон материалуудад эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал боловсруулж өндөр оноо авсан нэгжийг сонгон шалгаруулсан гэдэг нь үндэслэлгүй, уг уг аргачлалыг сонгон шалгаруулах хурлын дараа баталсан, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн талаар хурлын тэмдэглэлд дурдагдаагүй байв. Тус сан нь сүүлийн жилүүдэд төсөл сонгон шалгаруулах зээлийг бие даан олгож байгаа бөгөөд бодлогын зээлийг арилжааны банкны шалгуураас доогуур шалгуур тавьж, зээл олгож байна. Зээл авсан 83 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын 20 гаруй нь тодорхой улс төрч, эсхүл нэр бүхий томоохон бизнес эрхлэгчтэй шууд хамааралтай (хамаарал бүхий этгээдүүд нь зээл авсан) байна.

Зөвлөмж 26. Төсвийн хөрөнгийг хуульд нийцээгүй, шаардлага хангахгүй эрх зүйн актыг удирдлага болгон захиран зарцуулахыг таслан зогсоох, тэдгээр эрх зүйн актыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.1-д тусгагдсан “улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх” үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах.

Сангийн сайд 2015 оны 335 дугаар тушаалаар “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх журам”-ыг батлахдаа Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасан “санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах”, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2-т заасан “Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.”, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “Сайд Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тэргүүлж буй яамныхаа аппаратад түшиглэж эрхлэх асуудлын хүрээнийхээ чиглэлээр зөвлөгөө, туслалцаа авч яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.” гэснийг тус тус үндэслэжээ.

Дээрх хуулиудын зохицуулалтыг энэхүү журмыг батлах эрх зүйн үндэслэл гэж үзэхээргүй байна. Тус журмаар цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах зардлыг төлөвлөх, санхүүжүүлэхэд мөрдөхөөр байхад сайдын тушаалаар дараахь хөрөнгийг зарцуулжээ. Тухайлбал, Сангийн сайдын 2016 оны 147 дугаар тушаалаар Маркет медрикс” ХХК-нд Засгийн газрын үйл ажиллагааны тухай товч танилцуулга, товхимол айл өрх бүрт тараах, телевизийн ролик болон радио нэвтрүүлэг бэлтгэн гаргах иргэдийн санаа бодлыг авах зорилго бүхий судалгааны ажилд 48 сая төгрөг, 2016 оны 219 дүгээр тушаалаар “Айсуй элч сан” ТББ-т Шийдлийн Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбоотойгоор Сангийн яамнаас хэрэгжүүлсэн онцлог томоохон ажлуудыг сурталчлах, тайлагнах, видео нэвтрүүлэг хийхэд 20 сая төгрөг, 2016 оны 242 дугаар тушаалаар иргэнд БНХАУ-ын Бээжин хотод ажилласан томилолтын сүүлийн 2

сарын байрны түрээсийн төлбөр 15,4 сая төгрөг, 2016 оны 340 тушаалаар “Шинэ алхам төв” ТББ-д Хүүхэд, залуучуудын оюуны хөгжлийг дэмжих, ЕБС-ыг төгсөгчдөд зориулан “Шинэ Алхам-2016” ном хэвлэхэд 8,7 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын гэрэлтүүлгийн үнэ 40.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын газарт Старекс маркийн машин худалдан авахад 25 сая төгрөг, 2016 оны 412 дугаар тушаалаар ЗГХЭГ-ын ахлах референтэд Гадаад оронд эмчлүүлэхэд зориулж 5 сая төгрөг, 2016 оны 425 дугаар тушаалаар Төсөв, санхүүгийн чиглэлээр хууль, тогтоол боловсруулахад 25 сая төгрөг, 2017 оны 27 дугаар тушаалаар Австри улсад болох “Тусгай олимп”-ийн өвлийн тоглолтод оролцох тамирчдын замын зардалд 25,2 сая төгрөг, 2017 оны 73 дугаар тушаалаар 2017 оны төсвийн тодотголын төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаарх иргэдийн байр суурь, хандлага тодорхойлох судалгаанд 9,9 сая төгрөг, 2017 оны 74 дүгээр тушаалаар Орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн хяналтын талаарх иргэдийн байр суурь, хандлагыг тодорхойлох судалгаанд 9,9 сая төгрөг, 2017 оны 64 дүгээр тушаалаар Хувийн хөрөнгө оруулалтын сангийн судалгаа хийхэд 49 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дээрх хөрөнгийн зарцуулалтаас харахад Сангийн сайдын төсвийн багцад хамаарахгүй зардлыг санхүүжүүлсэн тохиолдол байна.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 83 дугаар тушаалаар төслийн 8 ажилтны цалингийн хэмжээг тогтоохдоо Сангийн сайдын 2014 оны 160 дугаар тушаалыг, 2016 оны 21, 22, 46, 62 дугаар тушаалаар Филиппин, Япон, Бангладеш, Вьетнам улсад туршлага судлах аялал, хуралд 8 албан хаагчийг оролцуулахад зөвхөн Хөдөлмөрийн дотоод журмыг, 2016 оны 131 дүгээр тушаалаар Санхүү, захиргааны ажилтны сургалтын зардалд 5,3 сая төгрөг олгоход Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/127 дугаар тушаалыг, 2016 оны 51 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлын зардалд 1,87 сая төгрөгийг зарцуулахад Эрүүл мэндийн сайдын 2013 оны 247 дугаар тушаалыг тус тус үндэслэн шийдвэрлэсэн байна.

Зөвлөмж 27. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагыг төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээлгэн, авлига үүсэх нөхцөл бүрдүүлж байгаа зохицуулалтыг хянан үзэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга болон Нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулдаг ба Нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний нэг заалт нь нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа байдаг бөгөөд сүүлийн хоёр жил тус бүр 1 тэрбум орчим төгрөгийн орлого төвлөрүүлэх чиг үүргийг дээрх гэрээнд тусгасан байдалтай байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т заасан “Мэргэжлийн хяналтын байгууллага улсын төсөвт орлого оруулах чиг үүргийг хүлээхгүй” гэж заасантай нийцэхгүй мөн гэрээнд төсөвт орлого төвлөрүүлэхээр тусгаж байгаа нь мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимтай нийцэхгүй байгаагийн зэрэгцээ авлигын эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Зөвлөмж 28. Төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжий дагуу шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Албан тушаалтныг ажлаас чөлөөлсөн яамны удирдлагын хууль бус шийдвэрийг шүүх хүчингүй болгож, албан тушаалтныг ажилд нь эгүүлэн томилсны улмаас тэдгээрт ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг улсын төсвөөс төлж, төсөвт дарамт учруулдаг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг зөрчил арилахгүй байна. Тухайлбал, 2016, 2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нийт 30.3 сая төгрөгийн нөхөн олговор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2 албан хаагчид нөхөн олговор 19,9 сая төгрөг, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт 6 ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн тул 35,2 сая төгрөгийн нөхөн олговор олгохоор болсон байна. Эрүүл мэндийн яамнаас 9 албан хаагч Захиргааны хэргийн шүүхэд хандсан бөгөөд тэдгээрээс энэ оны нэгдүгээр улирлын байдлаар шүүхийн шийдвэрийн дагуу 2 албан тушаалтныг ажилд нь эгүүлэн томилж, тэдгээрт ажилгүй байх хугацааны цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлд төсвийн хөрөнгөөс нийт 62.151.277 төгрөгийг олгосон бөгөөд 49.663.484 төгрөгийг төлж барагдуулахаар болсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 12 албан тушаалтныг хууль бусаар ажлаас чөлөөлсөн холбоотойгоор 224.412.624 төгрөгийг, Нийгмийн даатгалын ерөнхий газар 3 албан хаагчид шүүхийн шийдвэрээр 18.834.854 төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1 албан тушаалтанд 6.134.510 төгрөгийг, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 2016 онд 65.151.968 төгрөгтэй тэнцэх хэмжээний нөхөн олговрыг олгожээ. Түүнчлэн 2018 оны төсөвт мөн хууль бус шийдвэрийн улмаас төлөх нөхөн олговор олгохоор хөрөнгө төсөвлөгдсөн. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан, чөлөөлөгдсөн этгээдийг ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулан, төсөвт дарамт учруулахын зэрэгцээ төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг алдагдуулахад хүргэсэн байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн дагуу хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн тул хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, практик тогтоох нь чухал байна.

Зөвлөмж 29. Төрийн албан хаагчийн урамшуулалтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, төрийн өмчит хувьцаат компаниудын ажилтан, албан хаагчдын цалин, урамшуулалд харьцуулсан судалгааг хийж, компанийн ашигт ажиллагаа, ажлын үр дүн зэрэг хүчин зүйлсийг харгалзан урамшууллын нэгдсэн жишиг тогтоон мөрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/32 дугаар тушаалаар зөвлөлийн гишүүдэд 1 удаагийн хуралд оролцоход 1 гишүүнд 25000 төгрөгийн урамшуулал олгосон байна. Монгол Улсын

яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10-д “Төрийн нарийн бичгийн даргад зөвлөх үүрэг бүхий яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нараас бүрдсэн зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн ажиллах журмыг Төрийн нарийн бичгийн дарга батална” гэж заасан. Тухайлбал, Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох асуудлыг хуулиар зохицуулаагүй, эрх олгоогүй байхад Төрийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг баталж олгосон байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан тушаалтнууд нь УИХ-ын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолд заасан 16 орд буюу бусад ордтой холбоотой асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, төсөв хөрөнгийг батлах, нөөцийг тогтоох, хяналт шалгалт явуулах үйл ажиллагаанд шинжээчээр томилогдох буюу ажлын хэсэгт орж ажиллахдаа цалингаас гадуур нэмэлт урамшуулал авдаг.

“Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь сар бүр ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, үндсэн цалингийн 30-50 хүртэл хувьтай тэнцэх нэмэгдэл, урамшуулал олгодог бөгөөд 2016 онд 1 тэрбум 96 сая, 2017 оны эхний улиралд нийт 450.683.862 төгрөгийг зарцуулсан бол “Эрчим хүчний хөгжлийн төв” УТҮГ нь сар бүр цалингийн 10-50 хүртэл хувийн нэмэгдэл, урамшуулал олгож, 2015 онд 226.476.340 төгрөг, 2016 онд 258.900.765 төгрөг, 2017 оны 1 дүгээр улиралд 111.995.617 төгрөгийг урамшуулалд зарцуулжээ.

Гэтэл “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа 2012 оноос доголдож тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах болон ажилтны цалин, хөлс олгох боломжгүйд хүрч, улмаар 2015 онд санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар “хязгаарлалттай” гэсэн санал, дүгнэлт авчээ.

Зөвлөмж 30. Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.3.2/төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх/-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Засаг даргын нөөц хөрөнгө нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.1-д зааснаар “Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон тухайн шатны Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой **цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх**”-д зориулагдахаар байна. Түүнчлэн мөн журмын 2.3-т “энэ журмын 2.1.1/Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах/, 2.1.2 дахь хэсэг/Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах/-т

заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэж заасан. Гэтэл ихэнх дүүрэгт Засаг даргын нөөц хөрөнгийг “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3.-д заасныг үндэслэл болгон, баяр ёслол, тэмцээн, уралдаан, наадам, шагнал, урамшуулал, туршлага солилцох аялал зэрэг үйл ажиллагаанд зарцуулж, нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг нөөцөд байлгах шаардлагыг хангаагүй байна.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3.-д “Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх” гэдэгт ямар арга хэмжээг хамруулахыг нарийвчлан зохицуулаагүй байна.

УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 1.2.5-д төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх; Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг хэрэгжүүлээгүй. Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2015 онд Улаанбаатар хотын “Хүндэт тэмдэг”, “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, хотын захирагчийн “Жуух бичиг”-ийг дагалдах мөнгөн шагналд 77.6 сая төгрөг, 2016 онд Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажилд идэвхтэй оролцсон комиссын гишүүн албан хаагчдыг урамшуулах, Нийслэлийн Боловсролын газрын 85 жилийн ой, Монгол багш нарын өдрийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, дүүргийн Засаг дарга, Тамгын газрын дарга, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харъяа байгууллагууд, тэдгээрийн дарга нарыг урамшуулахад нийт 214.5 сая төгрөг зарцуулжээ.

Багахангай дүүргийн Засаг даргын 2015 оны А/267 дугаар захирамжаар дүүргийн “Шинэ жилийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 4,6 сая төгрөг, А/277 дугаар захирамжаар “Санхүү, эдийн засгийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан шагналд 5.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Тус дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөд 2015 онд батлагдсан төсөв 88.0 сая төгрөгөөс 87.6 сая төгрөгийг, 2016 онд батлагдсан төсөв 92.0 сая төгрөгөөс 92.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2016 оны А/130 захирамжаар 1,7 сая төгрөгийг волейболын тэмцээнд амжилттай оролцсон тамирчдыг урамшуулахад, 2016 оны А/86 захирамжаар 27,3 сая төгрөгийг сагсан бөмбөгийн лигийн тэмцээн зохион байгуулахад тус тус зарцуулсан, Засаг даргын нөөц хөрөнгөд 2015 онд батлагдсан 500 сая төгрөгөөс 497,9 сая төгрөгийг, 2016 онд батлагдсан 450 сая төгрөгөөс 413,8 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс БНХАУ-ын “Хөх хот”, “Эрээн” явах гадаад томилолтын зардалд нийт 9.3 сая төгрөгийг зарцуулсан. Мөн Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал, урамшуулал, тэмцээн уралдаан, наадам, туршлага солилцох аялалд, хүндэтгэл үзүүлэх, баяр тэмдэглэх, мэндчилгээ хүргэх зэрэг зардалд тус тус зарцуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар 2015-2016 онуудад Засаг даргын нөөц хөрөнгөөс иргэдэд буцалтгүй тусламж олгосон нь уг сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй гэж дүгнэхээр байна.

Чингэлтэй дүүргийн Засаг дарга нь дүүргийн Засаг даргын 2014 оны “Шагналын төрөл, түүнийг олгох журам батлах тухай” А/21 дүгээр захирамжаар дүүргийнхээ иргэд, албан хаагчдыг шагнадаг бөгөөд 2015 онд 629, 2016 онд 902 удаа, 2016 оны 5 дугаар сард 156 удаа тус тус шагнал олгосон байна. 2016 оны 5 дугаар сард олгосон шагналын тоо өмнөх оны мөн үеийнхээс 144-өөр буюу 13

дахин их байна. Энэ нь 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдөр болсон УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй юм. Чингэлтэй дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2016 онд батлагдсан төсөв 500.0 сая төгрөгөөс 499.9 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд шагнал, урамшуулалд 132 сая төгрөг зарцуулсан.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2015 онд 522.6 сая төгрөг, 2016 онд 591.4 сая төгрөг, 2017 оны эхний улирлын байдлаар 263.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Үүнээс 2015 онд Одонтой эхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 18.6 сая төгрөг, ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 75.3 сая төгрөг, 2016 онд Одонтой эхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 31.9 сая төгрөг, Цагаан сараар 84.4 сая төгрөг, 2017 онд ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 121.9 сая төгрөг, Одонтой эхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 69.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Налайх дүүрэг тэмцээн зохион байгуулах, шагнал, санхүүгийн дэмжлэг олгоход 2015 онд 139,2 сая төгрөг, 2016 онд тэмцээн зохион байгуулахад 135.0 сая төгрөг, 2017 онд 31,6 сая төгрөг тус тус зарцуулсан.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2015 онд шагналд 9.9 сая төгрөг, 2016 онд тэмцээн уралдаан, наадам, туршлага солилцох аялалд 18.6 сая төгрөг, хүндэтгэл үзүүлэх, баяр тэмдэглэх, мэндчилгээ хүргэхэд 25.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Үүнээс гадна Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1-д "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 5.2-т "Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/ Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулж байна" гэж заасан байдаг ч 2015 оноос хойш зөвлөл хуралдсан тэмдэглэлүүдтэй танилцахад Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотойгоор хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал байгаагүй юм.

Дөрөв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр:

Зөвлөмж 31. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд батлан хэрэгжүүлснээс хойших хугацаанд 27 удаагийн хуулиар 240 гаруй нэмэлт, өөрчлөлт орсон нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасан "...тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон бол шинэчлэн найруулгын төсөл боловсруулах..." шаардлагын түвшинд хүрсэн гэж үзэж байна.

Зөвлөмж 32. Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор байгуулсан орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой болох хүртэл түдгэлзүүлэх.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 2-т "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ. Дарга, орон тооны бус гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө." гэсний дагуу Засгийн

газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор орон тооны бус зөвлөлийн гишүүдийг томилсон. Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хууль тогтоомжид огт тусгаагүй байхад уг зөвлөл нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудлаар тогтоол гаргаж, дүрэм, журам батлан мөрдүүлж байна. Энэ нь нэг талаас хуулиар олгогдоогүй эрх хэмжээг хэрэгжүүлсэн, нөгөө талаас баталсан дүрэм, журам нь хүчин төгөлдөр бус шийдвэрт тооцогдох эрсдлийг бий болгож байна.

Зөвлөмж 33. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуулиар хүлээсэн чиг үүргээ бие даан гүйцэтгэх нөхцөлийг хангах.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 1, Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” 2016 оны 12 дугаар тогтоолд зааснаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг. Гэтэл тус газар нь хуучин Төрийн өмчийн хороо байх үеийн практикийн дагуу ажиллаж, зөвлөлийн Ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг, агентлагийн дарга нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтад холбогдох асуудлаар бие даан шийдвэр гаргах боломжгүй, зөвлөлийн тогтоолыг үндэслэн шийдвэр гаргаж байна.

Зөвлөмж 34. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн үр дагаврыг сайтар тооцож байгуулах талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг үндэслэн хэрэгцээ, шаардлага нь тодорхой бус орон нутгийн өмчит хуулийн этгээдийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олон тоогоор байгуулдаг, тухайн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагаар ихэвчлэн иргэдийн Хурлын төлөөлөгчид томилогддог, олонх хуулийн этгээд орон нутгийн төсвөөс татаас аван ажиллаж байна, Тухайлбал, Баянгол дүүргийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨТҮГ нь 12 хүний орон тоотой /дарга, дэд дарга, ахлах мэргэжилтэн, ня-бо, жолооч тус бүр 1, мэргэжилтэн 7/. Орон нутгийн төсвөөс санхүүждэг, 2017 оны нийт төсөв 146.253.000 төгрөг, үүний 62% нь ажилтны цалин хөлсөнд зарцуулагддаг, 10 орчим сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, мөн "Баянгол-Агропарк" ОНӨУТҮГ нь 11 хүний орон тоотой /дарга 1, дэд дарга 1, мэргэжилтэн 5, ня-бо, нярав, диндрологч, сахиул тус бүр 1/. Орон нутгийн төсвөөс санхүүждэг, 2017 оны нийт төсөв 131.172.100 төгрөг, үүний 70% нь ажилтны цалин хөлсөнд зарцуулагддаг зэрэг нөхцөл байдлууд тогтоогдсон. Цаашид орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулах асуудал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн бүрэн эрхийн асуудал хэдий ч Засгийн газар, өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч байгуулдаггүй учраас хяналтын механизм байхгүй байна.

Зөвлөмж 36. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг батлах тухай” 2016 оны 118 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын “Орон тооны бус зөвлөлийн гишүүдийн 1 удаагийн хуралдаанд оролцсоны урамшууллын хэмжээг тогтоох тухай” 2016 оны А/46 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгох.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг бүрдүүлэгч дарга, орон тооны бус найман гишүүн” нь хуралдаан зохион байгуулах, дэг батлах, тогтоол гаргах буюу гаргах шийдвэрийн төрөл, гишүүд урамшуулал авч болох зэрэг асуудлаар зохицуулалт байхгүй байхад дээр дурдсан тогтоолын “Дөрөв”-ийн 4.18-д “...Хуралдаанд оролцсон гишүүнд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг үндэслэн зохих хэмжээний урамшуулал олгож болно.” гэсэн, үүний үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2016 оны А/46 дугаар тушаалаар гишүүдийн нэг удаагийн хуралдаан (*Ээлжит хуралдаан нь 7 хоногт 1 удаа буюу Мягмар гарагт, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдаан зарлан хуралддаг*)-д оролцсоны урамшууллыг 70000 /далан мянга/ төгрөгөөр тогтоосон. Урамшуулын хэмжээ тогтоохдоо Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэсэн. Эдгээр хуулийн зохицуулалт нь урамшууллын хэмжээ тогтоох эрх хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад олгосон зохицуулалт биш байна.

Зөвлөмж 35. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг нэр заан томилох, чөлөөлөхөөр чиглүүлж байгааг зогсоож, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилохдоо өрсөлдөөнт шалгаруулалтын аргаар томилдог, үр дүнг тооцдог тогтолцоо нэвтрүүлэх.

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын “Хоёр”-ын 2.4-2.10-т зааснаар төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилох, чөлөөлөх, удирдамж чиглэл өгөх эрхийг Засгийн газар, Сангийн яам, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байгаа нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого, чиглэлд нэгдсэн зохицуулалт үгүйлэгдэж буйг харуулж байна.

Тухайлбал:

- “Эрдэнэс Монгол” ХХК, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газар;
- “Эрдэнэс Таван толгой” ХК болон “Эрдэнэс Оюу толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн Хурал /Засгийн газар/;
- “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиглэл болгосны дагуу** “Эрдэнэс Оюу толгой” ХК нэр дэвшүүлж, “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал;
- Төрийн банк болон Хөрөнгийн бирж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал”, “Арилжааны төлбөр тооцоо”, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Сангийн яам;
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг **Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
- бусад төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус томилж, чөлөөлдөг болно.

Мөн дээрх журмын “Хоёр”-ын 2.7-д “Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Хөгжлийн банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3-т заасны дагуу Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн нь хуульд байхгүй зүйл, хэсгийг дурдсан техникийн алдаатай байх тул хуульд нийцүүлэх нь зүйтэй.

Зөвлөмж 37. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний цалин хөлсний хэмжээ, хязгаарлалтыг тогтоох шалгуур, арга зүй, аргачлалыг бий болгож, мөрдүүлэх.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний цалин хөлс нь тухайн хуулийн этгээдийн орлого, эдийн засгийн үр дагавраас үл шалтгаалан сарын 450000-2500000 төгрөгөөр тогтоосон нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын “Гурав”-ын 3.7-д заасан “Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.” гэснийг зөрчжээ.

Зөвлөмж 38. Эдийн засгийн үр ашиггүй, өөрийгөө санхүүжүүлэх чадваргүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын болон зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, алдагдалтай ажиллаж буй байгууллагыг өөрчлөх, нэгтгэх, татан буулгах зэргээр төсөв, санхүүгийн зардал, төсвөөс олгох татаасыг үе шаттайгаар бууруулах, санхүүгийн хариуцлагыг чангатгах арга хэмжээг авах.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн эдийн засгийн үзүүлэлттэй танилцахад нийт 92 хуулийн этгээд 4,5 их наяд төгрөгийн орлого олж, 4,7 их наяд төгрөгийн зардал гаргасан байх ба эдгээр аж ахуйн нэгжийн 45,6 хувь буюу 42 нь алдагдалтай ажилласны дотор 1-ээс 20 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан 10 байгууллага байлаа. Энэ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй өрсөлдөн ашиг олж, төрийн сан хөмрөгийг арвижуулах гол зорилго ямар түвшинд байгааг илэрхийлэх бодит үзүүлэлт тул ашиггүй ажиллаж буй аж ахуйн нэгжийг өөрчлөн зохион байгуулах, оновчтой зохион байгуулалт хийх шаардлагатайг харуулж байна.

Зөвлөмж 39. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд хувийн компаниудаас үл хөдлөх хөрөнгө(байр, талбай)-ийг түрээслэхэд жил бүр олон тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулж байгааг зохистой байдлаар шийдвэрлэх, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай, зарцуулах.

Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 11-д заасны дагуу төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтоон хэрэгжүүлдэг ба ТӨБЗГ-ын

2016 оны 119 дүгээр тогтоолоор албан тасалгааны зориулалтаар түрээслүүлэх 1 метр.квадрат ашигтай талбайн жишиг үнийг 15000 төгрөг байхаар тогтоосон.

Өөрийн эзэмшлийн байргүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой **16 хуулийн этгээд жилд 2,2 тэрбум** гаруй төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулснаас зөвхөн Геологийн судалгааны төв ТӨҮГ төрийн өмчийн үйлдвэрийн газрын байрыг түрээсэлж, бусад 15 хуулийн этгээд нь хувийн компаниудаас ажлын байр, талбай түрээсэлсэн байна.

Дээрх 16 хуулийн этгээдийн 25 хувь буюу 4 нь 1000 метр.квadrатаас дээш талбай бүхий албан тасалгааг түрээсэлж, 1 метр.квадрат талбайн төлбөрт 23000-43000 төгрөг төлжээ. Тухайлбал, төрийн өмчийн "Эрдэнэс Монгол", "Эрдэнэс Метан", "Эрдэнэс Ассет менежмент", "Эрдэнэс шивээ энерги", "Гашуун сухайт авто зам" ХХК-иуд нь Моннис цамхагт байрлаж, жилд 785,6 сая төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулж байна.

2016 оны жилийн эцсийн эдийн засгийн үзүүлэлтээр 20 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан "Монголын төмөр зам" ХК нь сард - 32,8 сая, жилд - 393,6 сая төгрөг; 9,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан "Монгол тамга" ТӨҮГ нь сард - 1,3 сая, жилд - 15,9 сая төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулжээ. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн байрыг өндөр үнээр түрээслэх тохиолдлууд ч цөөнгүй байгаа нь санхүүгийн эх үүсвэрийг үр ашиггүй зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Зөвлөмж 40. Зарим агентлаг болон аж ахуйн тооцоот болон төсөвт үйлдвэрийн газрын чиг үүрэг, зохион байгуулалт, статусыг нь өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ авах.

Төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай "хөгжлийн", "аж ахуйн тооцоот" гэсэн тодотголтой Барилгын хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Автотээврийн үндэсний төв зэрэг байгууллагууд нь дүрмээрээ төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байна. Эдгээр байгууллагууд үйлчилгээний хөлс, төлбөр хураамж тогтоон иргэдийг чирэгдүүлдэг, салбарын яамны зарим үйл ажиллагааг санхүүжүүлдэг, мөн өөрсдөө тусгай зөвшөөрөл эзэмшигч байж бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч (хувийн хэвшлийн)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр тэнцвэргүй үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал:

- Авто тээврийн үндэсний төв нь дүрмээрээ техникийн бүрэн байдлыг тогтоох дүгнэлт гаргах, Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээ (бүртгэл хөтлөх, автотээврийн хэрэгслийн улсын дугаар олгох, автотээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ олгох), мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгохын зэрэгцээ хот хооронд, улс хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж, бусад тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг;

- Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2012 оны Б/36 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам"-ыг баталж, тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнэ 100.000 төгрөг /нэг удаа/, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнэ гэж 6 төрлийн 26 ажилд 100.000 -1.600.000 төгрөгийн хураамж тогтоосон;

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2015 оны А/01 дүгээр тушаалаар байрны нэг ор хоногийн төлбөр 2000 (60000) төгрөг, сургалтын түрээсийн 1 цагийн төлбөр 6500 төгрөг, түрээсийн өрөөний 1м²-ын төлбөр 5500 төгрөг, авто гаражийн түрээсийн төлбөр 1 хоногт 5000 төгрөг байхаар тус тус тогтоосон.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг боловч эрхлэх үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж тус байгууллагын дарга, дэд даргаас бусад албан хаагчид нь төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамаардаггүй улсын үйлдвэрийн газрын жишгээр цалинжиж, Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд ажилтан, албан хаагч нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг алдагдуулсан, мөн хууль бусаар ажлаас чөлөөлсний нөхөн олговор, ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх зэргээр улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна.

Зөвлөмж 41. “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн гэрээний үүргийн биелэлт, орлого төвлөрүүлэлт, зарцуулалтад тавих хяналтын тогтолцоог сайжруулах, “Монгол Улсын Далайн захиргаа” Улсын төсөвт үйлдвэрийн газрын статусыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцүүлэх.

Монгол Улс 1996 онд Далайн эрх зүйн байдлын тухай НҮБ-ийн конвенцод элсэн орж, улмаар Засгийн газрын “Их далайг ашиглах талаар авах арга хэмжээний тухай” 1996 оны 396 дугаар тогтоол гарч, 1999 онд Далай ашиглах тухай хуулийг баталсан байна.

Дээрх хуулийг үндэслэн 2001 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газар болон Сингапур улсын “Маритайм Чейн” компани хамтран Сингапур улсад “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компани байгуулагдсанаар өнөөдрийн байдлаар Монголын тал 70 хувь, Сингапурын тал 30 хувийн хувьцааг эзэмшиж байгаа хэдий ч “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн бүртгэсэн онгоцны тоо, олсон орлого нь харилцан адилгүй байна. Тухайлбал, 2003-2008 оны хооронд 5 жилийн хугацаанд “Монголын хөлөг онгоцны бүртгэл”-ээс нийт 1565 хөлөг онгоцноос 6.7 сая ам.доллар олж төсөвт 1.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байхад 2009-2016 оны эхний хагас жилд буюу 7 жилийн хугацаанд 1511 хөлөг онгоцноос 9.4 сая ам.доллар олж улсын төсөвт 1.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь хөлөг онгоцны тоон үзүүлэлт нэмэгдсэн боловч орлого, ашиг нь буурсан үзүүлэлттэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 128 дугаар тушаалаар Монгол Улсын Далайн захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн баталсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д зааснаар “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын чиг үүрэгт хамаарах бөгөөд “Монгол Улсын Далайн захиргаа” /регистр 5292816/ Улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн хуулийн этгээдийн статусаар үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт бүртгэлгүй, хамааралгүй байгаа нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна.

Иймд “Монгол Улсын Далайн захиргаа” Улсын төсөвт үйлдвэрийн газрын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг хууль, тогтоомжид нийцүүлэх, мөн үндсэн үйл ажиллагаа явагддаг Сингапур улсад бүртгэлтэй “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Тав. Худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах чиглэлээр:

Зөвлөмж 42. Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлт оновчтой бус, ил тод байдал хангалтгүй, гүйцэтгэлд тавих хяналт сул, хариуцлага тооцох эрх зүйн орчин боловсронгуй бус байгаа нь авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлж байгаад онцгой анхаарал хандуулах, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 4.1.4.1, 4.1.4.2/тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох/, 4.1.1.3/худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх/-д тусгасан үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлэх.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д “энэ хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ”, 53.7-д “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна” гэж заасан. Гэтэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт төсөл, арга хэмжээний зөвхөн 0,69 хувийг хэрэгжүүлсэн, цахим худалдан авалтын нэгдсэн систем ашиглалтад орсон боловч байгууллагууд тендерийг уламжлалт аргаар буюу цаасан хэлбэрээр явуулсан.

Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг байгууллагууд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэдээлээгүй, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг байгууллагууд тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэл, шалтгааныг тус байгууллагын цахим хуудаст иргэд мэдээлэл авахад энгийн ойлгомжтой байдлаар байршуулаагүй байв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлд “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасан байхад 2016 оны 12 дугаар сарын 30-нд “Эйч Энд Эйч” ХХК-аас Нийслэлийн Өргөө амаржих газарт Эрүүл мэндийн яамны “Хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн /21 аймаг/ Багц-2 гэрээ”-ний хүрээнд нийлүүлсэн Иммунологийн анализатор шинжилгээний багажийн шинжилгээ хийхэд шаардагдах урвалжийн санхүүжилтийг тухайн эмнэлгийн төсөвт нь давхар шийдэж өгөөгүйн улмаас одоог хүртэл ажиллах боломжгүй байна.

2015 онд Эрүүл мэнд, спортын сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын 51 төсөл арга хэмжээний 28 нь бүрэн хэрэгжээгүй. Тухайлбал, Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд хэрэгжсэн эмнэлгийн барилгын анхны төсөвт тусгагдаагүй нэмэлт ажлууд гарснаас төсөвт өртөг нэмэгдсэн., гадна тохижилт,

гарааш, гүний худгийн ажил хугацаандаа хийгдээгүй. Сонгинохайрхан дүүргийн 700 хүний суудалтай спорт цогцолборын барилгыг анх баталгаажуулахгүй төсвөөр төсөвт тусгаснаас төсөвт өртөг 1,080.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, барилгын ажил дуусаагүй байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 3 дугаар шатлалын лабораторийн барилгын гүйцэтгэгч “Энигма” ХХК нь тоног төхөөрөмж худалдан авахад 2014 онд гүйцэтгэл гарган 2,269.9 сая төгрөгийн санхүүжилтийг авсан боловч тухайн ажил хийгдсэн эсэх нь тодорхойгүй.

Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоолд “2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс хойш бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулахгүй байх, 2015 оны 08 дугаар сарын 31-ээс өмнө гэрээ байгуулж, гүйцэтгэл нь бүрэн санхүүжигдээгүй арга хэмжээний зардлыг 2016 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах, Улсын төсөв, хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон 2015 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар гэрээ нь байгуулагдаагүй, ажлын гүйцэтгэл удаашралтай байгаа нь тогтоогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дараа онуудад шилжүүлэх” гэж заасан байхад 2015 оны 10 сард Бельги улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах” төсөл, 11 сард Ховд аймгийн Булган сумын “Сум дундын нэгдсэн эмнэлгийн барилга”-ын төсөл, 12-р сард Гэмтэл согог судлалын үндэсний төвийн харъяа “Түлэнхийн төвийн барилгын Б блокын барилга”, Баянхонгор аймгийн Баянцагаан “Сумын 14 ортой эмнэлгийн барилга” зэрэг ажлын гэрээ байгуулах эрхийг тус тус оройтуулж олгосны улмаас барилгын ажил улирлын байдлаас шалтгаалж зогссон ба санхүүжилтийг улсын төсөвт эргүүлэн татсан. 2016 онд энэ байдал дахин давтагдаж 11 төсөл арга хэмжээний худалдан авалт оройтож явагдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.5-д “тендерт оролцогч нь хээл хахууль санал болгох, дарамт шахалт үзүүлэх зэргээр тендер шалгаруулалтын дүнд нөлөөлөхийг оролдвол энэ тухай өөрийн шууд харъяалан удирдах албан тушаалтан, хууль, хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэх”, 14 дүгээр зүйлийн 14.1.2-т “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” бол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзэхээр хуульчилсан байхад Онцгой байдлын ерөнхий газар татварт өртэй компаниас ирүүлсэн тендерийг удирдлагаас өгсөн үүргийн дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үнэлэн гүйцэтгэгчээр шалгаруулж, аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу нийлүүлэх ёстой автомашинуудыг Монгол Улсад оруулж ирээгүй байхад хүлээн авсан тухай хуурамж акт үйлдэж, санхүүжилт гаргуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д “гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэж болно” гэж заасныг баримтлан 2015 оны 9 дүгээр сар, 11 дүгээр сард галын хучлагыг шууд худалдан авалтын гэрээгээр авч нийлүүлсэн ба үүнийг 2016 оны 5 дугаар сард гарсан гал түймрийн гамшигтай холбогдуудан худалдан авсан гэж баримт бүрдүүлсэн байна.

Хөдөлмөрийн яам 2016 онд нийт 44 байгууллагатай 3,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 46 төслийн гэрээ байгуулж, 2,9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүний 1,4 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрөөс, 2,3 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус тус санхүүжүүлжээ.

Эдгээр төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан, аж ахуйн нэгжүүдийг сонгох болсон шалгуур үзүүлэлтүүд, ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлт, хурлын тэмдэглэл байхгүй байв. Түүнчлэн 2016 онд барилга барих газар, техникийн нөхцөл бэлэн болоогүйгээс 67,0 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Тендерийн материалд гэрээ дүгнэсэн акт хавсаргаагүй, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй, тендерийн баримт бичгийг шилжүүлсэн, хүлээлгэн өгсөн бүртгэл хөтлөөгүй байв.

Эрүүл мэндийн яам төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төсөвт өртгийн тооцооллыг бодитой хийгээгүй, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хугацаанд явуулдаггүй, гэрээний нөхцөл, гэрээний үүргийн явц байдал, биелэлтэнд хяналт тавих механизм сул, төсөл, арга хэмжээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх тайланг нэгтгэж аваагүй, тендерийн материалд улсын комиссын актыг хавсаргаагүй байв.

Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т “Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг энэ хуулийн 5.1.16-д заасан журмаар түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно”, Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэх зэрэг хоорондоо утга, агуулгын зөрүүтэй заалтуудыг удирдлага болгож байгаа нь төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөр байна. Тухайлбал, 2015 онд Говь-сүмбэр аймгийн Шивээговь сумын 15 ортой эмнэлгийн барилгын 1,110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын 14 ортой эмнэлгийн барилгын 1,013.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуульд заасны дагуу баталгаажаагүй боловч төсөвт тусгагдаж, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтөйгөөр тендер шалгаруулалт явагдсан.

Энэ нь дээр дурдсан хуулийн зүйл, заалтын зөрүүтэй байдлыг арилгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

2015 оны 10 дугаар сард Бельги улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах” төсөл, 11 дүгээр сард Ховд аймгийн Булган сумын “Сум дундын нэгдсэн эмнэлгийн барилга”-ын төсөл, 12 дугаар сард Гэмтэл согог судлалын үндсэний төвийн харьяа “Түлэнхийн төвийн барилгын Б блокын барилга”, Баянхонгор аймгийн Баянцагаан “Сумын 14 ортой эмнэлгийн барилга” зэрэг ажлын гэрээ байгуулах эрхийг тус тус оройтуулж олгосны улмаас барилгын газар, шороо болон суурийн бетон цутгалтын ажил улирлын байдлаас шалтгаалж зогссон бөгөөд санхүүжилтийг улсын төсөвт эргүүлэн татсан, 2016 онд энэ байдал дахин давтагдаж 11 төсөл арга хэмжээний худалдан авалт оройтож хийгдсэн байна.

Тендер сонгон шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхдээ хуульд заасан шаардлагыг хангаж ажиллаагүй, нээлттэй тендер шалгаруулалт явуулахын оронд төсөвт өртгийг хэд хэдэн ажил болгон хувааж, харьцуулалтын аргыг хэрэглэсэн, тендер шалгаруулалтын аргыг сонгосон үндэслэл, байгууллагуудад хүргүүлсэн урилга, бусад бичиг баримтын бүрдэл нь хуульд заасан шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, Батлан хамгаалах яам хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалтын аргыг хэрэглэхдээ 3 компанид үнийн санал хүргүүлсэн гэж холбогдох албан тушаалтан тайлбарлаж, 3 компанийн нэр бичсэн, тус яамнаас

явсан албан бичиг үзүүлэх боловч эдгээр компаниудыг хэрхэн сонгосон үндэслэл тодорхойгүй, урилга хүргүүлснийг баталгаажуулсан баримт байхгүй, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 30 саяас дээш, 90-290 хүртлэх сая төгрөгийн төсөвтэй 13, 40-80 хүртэлх сая төгрөгийн төсөвтэй 20 ажил, үйлчилгээг худалдан авахдаа нээлттэй тендер зарлахгүйгээр харьцуулсан болон шууд худалдан авах гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн.

Гадаад харилцааны яам 2015-2016 онуудад Монгол Улсад зохион байгуулагдсан Ази-Европын дээд хэмжээний 11 дэх уулзалт, дагалдах 9 хуралдааныг зохион байгуулах ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн захирамж, Гадаад харилцааны сайдын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн тушаалыг үндэслэн 2015 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/75 дугаартай Гадаад харилцааны сайдын тушаалаар АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны бүтцийг баталсан байна. Тус ажлын алба нь 2015-2016 онуудад нийт 19,268,700,000 төгрөгийн худалдан авалтыг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 дугаартай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дэх заалтыг тус тус үндэслэн нэр бүхий аж ахуйн нэгжүүдтэй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. Ингэхдээ "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн түүний хүрээнд төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр боловсруулан гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ" гэсний дагуу Гадаад харилцааны яам Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Монгол Улсад Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагааг төрийн нууцад хамааруулсан шийдвэр гаргаагүй, бүх бичиг баримтад нууцын тэмдэг дарагдаагүй байна. Дээрх худалдан авалтуудын тайлан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан акт, гэрээний биелэлт зэргийг ихэнх компаниуд өгөөгүй, ажлын алба тус компаниудаас нийлүүлж буй бараа, ажил үйлчилгээг хүлээн авч үнэлээгүй, баримт бичиг эмх цэгцгүй байв.

Энэ нь цаашид олон улсын түвшний нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад олон улсын жишгийн дагуу нэг удаагийн үйлчлэлтэй, тухайн арга хэмжээтэй холбогдолтой асуудлуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн актыг боловсруулан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулан ажиллах шаардлагатайг харуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын худалдан авах ажиллагааны 70 орчим хувьд шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн, Сангийн яам Засгийн газрын үйл ажиллагааг харуулсан 18 сэдэв бүхий телевизийн ролик хийж, нэвтрүүлэхэд төсөвлөгдсөн 200 сая төгрөгийг тус бүр 50 сая төгрөгийн төсөвтэй 4 ажил болгон хувааж, харьцуулалтын аргаар тендер худалдан авах нэрээр материал бүрдүүлэн "Торус энтертайнмент" ХХК-ийг бүх худалдан авах ажиллагаанд шалгаруулж, гэрээ байгуулсан, Батлан хамгаалах яам жил бүр тогтмол зохион байгуулагдаж буй "Оюутан цэрэг" хөтөлбөр, "Хааны эрэлд" сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан. Гаалийн ерөнхий газрыг 2016 онд нүүлгэн шилжүүлж, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах 270,950,000 төгрөгийг Сангийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 321 дугаартай тушаалаар шийдвэрлэж дээрх төсвийг 10 төсөл арга хэмжээ болгон задалсан байх боловч төсвийн урсгал засварт

төсөвлөгдсөн 177,034,000 төгрөгийн төсвийг дахин 3 хувааж харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Гаалийн ерөнхий газрын байрны урсгал засварын тендер, Гааль, татварын ерөнхий газрын мэдээллийн технологийн системийн аюулгүй байдлыг хангах вирусын програмын лиценз сунгах үйлчилгээний тендер зэргийг зохион байгуулахдаа төсөвт өртгийн дээд хязгаар барааны хувьд 50 сая төгрөг байхаар баталсан байхад харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион явуулж, босго үнээс дээш үнээр гэрээ байгуулсан.

Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулсан зарим худалдан авах ажиллагааг Сангийн яамнаас дахин зохион байгуулахыг даалгасаар байхад шууд гэрээ байгуулсан, дутуу гүйцэтгэлтэй ажил хүлээн авсан, нэг тендерт өөр хоорондоо хамааралтай 2 компанийг оролцуулсан.

Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор тендерт оролцогчдоос Сангийн яаманд ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо сүүлийн 3 жилийн байдлаар жил бүр өссөн, сүүлийн 3 жилийн дунджаар хүлээн авсан нийт гомдлын 50 орчим хувьд нь тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, эсхүл үнэлгээг дахин хийлгэхээр шийдвэрлэсэн нь худалдан авах ажиллагаан дахь зөрчил, дутагдал их байгааг харуулж байна. Тодруулбал, Сангийн яамны Хууль, эрх зүйн газар тендер шалгаруулалттай холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдлыг сүүлийн 3 жилээр авч үзэхэд, 2015 онд 588, 2016 онд 608, 2017 оны эхний 11 сарын байдлаар 758 гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэснээс 2015 онд нийт гомдлын 29 хувь буюу 176 нь, 2016 онд нийт гомдлын 27,1 хувь буюу 165 нь, 2017 оны эхний 11 сарын байдлаар нийт гомдлын 26,2 хувь буюу 199 нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 2015 онд нийт гомдлын 47,1 хувь буюу 277, 2016 онд 49,6 хувь буюу 302, 2017 онд 54,1 хувь буюу 410 нь захиалагчийн шийдвэр үндэслэлгүй буюу тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, үнэлгээг дахин хийлгэхээр шийдвэрлэсэн байна Түүнчлэн ХЗДХЯ-ны харьяа агентлагуудын худалдан авах ажиллагаатай холбогдуулан Сангийн яаманд 2016 онд 16 гомдол ирснээс 81.2% нь Цагдаагийн ерөнхий газар, 18.8% нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газартай холбоотой байсан. Эдгээр гомдлын 75% нь сонгон шаргаруулалтыг дахин хийлгэх, үлдсэн 25% нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, гомдлын хуулийн хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлээр шийдвэрлэсэн нь эдгээр байгууллагын худалдан авалтын үйл ажиллагаа зөрчил ихтэй байгааг харуулж байна.

Зөвлөмж 43. Гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хоцроосон хуулийн этгээдэд хариуцлага тооцох үр дүнтэй механизмыг бий болгох, энэ чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан хаагчдын болон ялтны нормын хувцас, зөөлөн эдлэл нийлүүлэх ХААГ-2015/Э003 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтанд “Жэй Эй Эйч” ХХК, “МПУМ” ХХК, “Тэс Эрдэнэ” ХХК зэрэг аж ахуй нэгж гэрээний хугацааг 14-56 хоногоор тус тус хэтрүүлсэн, “МПУМ” ХХК гэрээний үүргээ биелүүлэх биелүүлэх боломжгүй болсон тул гэрээг цуцласан боловч хариуцлага тооцоогүй байна.

Зөвлөмж 44. Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхижуулах, тендерийн үнэлгээний хороог байнгын бус ажиллагаатай байхаар зохион байгуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Үнэлгээний хороо нь байнгын бус ажиллагаатай байх...”, 47.4-т “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэж заасан. Гэтэл Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүн нь хуульд заасан шаардлагыг хангаагүй, үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргаагүй, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан цөөн байдгаас нэг албан хаагч тухайн жилд зарлагддаг ихэнх тендерт үнэлгээний хорооны гишүүнээр оролцдог, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон иргэдийн төлөөллийг оролцуулдаггүй, үнэлгээний хорооны гишүүд мэдэгдэл, тайлбар гаргахдаа багц ажил тус бүрд мэдэгдэл гаргаагүй, мэдэгдлийн маягтыг бүрэн бөглөөгүй зөрчил дутагдал нийтлэг байна.

Тухайлбал, Батлан хамгаалах яамны үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналтыг хуульд заасан шаардлагын дагуу оруулдаггүй, ахмадын хорооноос төлөөлөл оруулах байдлаар шийдвэрлэдэг. Ихэнх яам, агентлаг, байгууллагын үнэлгээний хорооны гишүүд байнга худалдан авах ажиллагаанд оролцдог.

Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн яамны худалдан авах ажиллагаа зохион байгуулах тендерийн үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргаагүй, Сангийн яамны хар жагсаалтад байгаа мэдээллийг ашигладаггүй ба сонгон шалгаруулалтад тэнцээгүй компаниудад хариу мэдэгдээгүй байгаа нь гомдол гаргах эрхийг хязгаарласан байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2015, 2016 онд зохион байгуулсан тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн хяналт тавих этгээд оролцох боломж бүрдүүлээгүй. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны А/166 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлэх” төслийн ажлын албанд ашиглах машин худалдан авах ажиллагааг зохион байгуулах, 2015 оны А/42 дүгээр тушаалаар “Нэг Ази 2015: Тогтвортой хөгжлийн зорилтод залуучуудын оролцоо” Азийн залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, Хөдөлмөр эрхлэлтийн төвийн захирлаас 2016 оны А/02, 05, 83, тушаалаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл сонгон шалгаруулах, ахмадын мэргэжилтний төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах, Хөдөлмөр халамжийн ерөнхий газрын даргын 2016 оны А/48, 2017 оны А/74 дүгээр тушаалаар тус тус байгуулсан Үнэлгээний хороонд иргэний нийгмийн, хөндлөнгийн хяналт тавих боломж олголгүйгээр хэрэгжүүлсэн. Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 58, 247 дугаар тушаалаар зөвлөх сонгон шалгаруулах, 2016 оны А/99 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн яамны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, А/100 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамны хурлын заалны тоног төхөөрөмж

нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, А/113 дугаар тушаалаар судалгааны ажил гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо, ЭМХТ-ийн захирлын 2015 оны А/69 , 2016 оны А/2 дугаар тушаалаар тус төвийн харуул хамгаалалтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг, мөн төвийн барилгын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог тус тус байгуулахдаа иргэний нийгмийн төлөөллийг оролцуулаагүй, иргэд олон нийт хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг хязгаарласан байна.

Зөвлөмж 45. Тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэсэн хуулийн заалтын хэрэгжилт зарим байгууллагад хангалтгүй байна. Тухайлбал, Барилга, хот, байгуулалтын яам 2015-2016 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Сангийн яамнаас тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан аж ахуйн нэгж тендерт оролцсон эсэхийг хянасан тухай тэмдэглэл хөтлөөгүй, хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байв. Хөдөлмөрийн яам 2016 онд нийт 44 байгууллагатай 3,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 46 төслийн гэрээ байгуулсан бөгөөд энэхүү ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төсөл сонгон шалгаруулсан ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, бусад холбогдох бичиг баримт байхгүй байв.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж, захиалагчид зөвлөмжийг хүргүүлснээр худалдан авах ажиллагааг дуусгадаг бөгөөд захиалагч байгууллага нь ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, гэрээг дүгнэж бараа, ажил үйлчилгээг хүлээн авдаг байна. Захиалагч байгууллага нь Нийслэлийн засаг даргын харьяа бүхий л газар, агентлагууд байдаг байх ба тус газрын архивт хадгалагдаж буй тендерийн материалд гэрээг дүгнэсэн комиссын актыг хавсаргадаггүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих нэгдсэн мэдээллийн сан байхгүй.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны худалдан авах ажиллагааг тус яамны Хөрөнгө оруулалтын хэлтэс нь хариуцан зохион байгуулан ажилладаг боловч тус хэлтсийн дарга, мэргэжилтэн нар өмнөх онуудын худалдан авах ажиллагааны талаар ямар нэгэн мэдээлэлгүй, өмнө нь хариуцан ажиллаж байсан ажилтан, мэргэжилтнүүд нь ажлаа хүлээлгэн өгөхдөө худалдан авах ажиллагааны талаарх холбогдох баримтуудыг үлдээгээгүй тул шаардлагатай зарим материалуудтай танилцах бололцоо байхгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын архивт хадгалагдаж байгаа тендерийн материалтай танилцахад зарим материалд гэрээ дүгнэсэн акт хавсаргаагүй, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлээгүй байна.

Газрын харилцаа геодези зураг зүйн газар нь Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 19 дүгээр зүйлийн 19.4, 22 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.1.8-д заасныг тус тус зөрчиж төрийн архивт хамаарах баримтуудыг байгууллахыг архивт хүлээлгэж өгөөгүй, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1, Сангийн сайдын баталсан “Үнэлгээний хорооны зохион

байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 2.2.5-д заасан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, үнэлгээний дүгнэлтэд гарын үсэг зурах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасныг заасны дагуу, тендерийн баримт бичиг бүрдүүлэлт нь шаардлага хангахгүй, худалдан авах ажиллагааны баримт бичиг нь эмх замбараагүй, 2016 оны Худалдан авах ажиллагааны баримт бичгийг архивт хавтаст материал болгон үдэж хадгалаагүй, бичиг баримтны бүрэн бүтэн байдал нь чанарын шаардлага хангахгүй байв.

Зөвлөмж 46. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын шинжтэй томоохон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг худалдан авах үйл ажиллагааны мэргэжлийн байгууллага аар гүйцэтгүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, цаашид энэ асуудлыг эрхлэх Засгийн газрын агентлаг байгуулах талаар судалж, шийдвэрлэх.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр улсын хэмжээнд 2017 онд нийт 4.17 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8,904 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 75.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээ буюу нийт худалдан авалтын дөнгөж 0.69 хувийг зохион байгуулсан нь яам, агентлагууд үндсэн үйл ажиллагааны худалдан авах ажиллагааг өөрсдөө зохион байгуулдагтай холбон тайлбарлаж болох юм. Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авалтын ажиллагааг мэргэжлийн байгууллага гүйцэтгэх шаардлагатай байна.

Зөвлөмж 47. Худалдан авах ажиллагаа (тендер)-ны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх. Ялангуяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд онцгойлон анхаарах.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар болон 21 аймгийн худалдан авах ажиллагааны албадаас бусад нь цахим хэлбэрээр тендер зохион байгуулдаггүй. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2016 онд /бүх сум нь/ 100 хувь цахим хэлбэрээр тендер шалгаруулалт зарласан байх бөгөөд энэ нь Монгол Улсын хэмжээнд 100 хувь цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан тендер шалгаруулалт зохион байгуулах боломжтойг харуулсан туршлага юм.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР